3	Увс, Ховдын дулааны станцын /+25-60 мм/	19	17,107
4	Хувь компанийн уурын зуух /-25 мм/	54	48,620
5	Нийт дүн	100	90,037

Уул уурхайн хүрээлэнгийн Нүүрсний шинжилгээний лабораторид ангилсан хэсэг тус бүрээс дээж авчруулан шинжлүүлсэн бөгөөд нүүрсний чанарын үзүүлэлтийг хүснэгтэд үзүүлээ.

Хүлээн авах бункер. Хүлээн авах бункерийн багтаамж нь үйлдвэрийн нүүрс өгөлтийн зохион байгуулалт, анхдагч нүүрсний хамгийн том ширхэглэлийн хэмжээ, технологийн шугамын хүчин чадал зэргээс хамааруулна.

Үл хөдлөх гулдмай сараалжин шигшүүр. Үл хөдлөх гулдмай сараалжин шигшүүрийг хүлээн авах бункерийн амсар дээр байрлуулах бөгөөд шигшүүр нь тууш завсар бүхий зэрэгцүүлж байрлуулсан гулдмай савхнуудаас бүрдэнэ. Савхнуудын хоорондох зайн хэмжээ 50 мм-ээс дээш байх бөгөөд шигшүүрийг нүүрс шигшихэд 40-50°-ийн налуутай байрлуулж өгдөг.

Тэжээгүүр. Тэжээгүүрийг анхдагч нүүрсийг бутлуурт өгөхөд хэрэглэх бөгөөд хүлээн авах бункерийн гарах нүхний доод талд байрлана. БНХАУ-ын Zhengzhou Great Wall Heavy Industry Machinery компанийн GZD1300x4900 маркийн 1 ширхэг чичиргээт тэжээгүүрийг ашиглана.

Хүснэгт 25. Тэжээгүүрийн техникийн үзүүлэлт

№	Үзүүлэлт	GZD1300x4900
1	Тээвэрлэх хэсгийн өргөн* урт, мм	1300*4900
2	Хамгийн том ширхэглэлийн хэмжээ, мм	800
3	Хүчин чадал, тн/цаг	180-450
4	Хөдөлгүүрийн чадал, кВт	22
5	Жин, кг	6680
6	Хэмжээ: урт*өндөр * өргөн, мм	5000x2350x1750

Бутлуур. Нүүрс харьцангуй хатуулаг багатай байдаг учир ихэвчлэн булт бутлуурыг хэрэглэдэг боловч Хар тарвагатайн ордын хувьд бутлах хэсэгт ирэх нүүрсний ширхэглэлийн хэмжээ харьцангуй том, хатуулаг нь дунд зэрэг, чулуун нүүрс учир хацарт бутлуур хэрэглэх нь илүү тохиромжтой гэж үзэн БНХАУ-ын Zhengzhou Great Wall Heavy Industry Machinery компанийн PE900x1200 маркийн хацарт бутлуурыг ашиглана.

Хүснэгт 26. Бутлуурын техникийн үзүүлэлт

№	Үзүүлэлт	PE900x1200
1	Хүлээн авах амсрын хэмжээ, мм	900x1200
2	Тэжээлийн хамгийн том ширхэглэлийн хэмжээ, мм	750

3	Гарах амсрын хэмжээ, мм	95-165
4	Хүчин чадал, тн/ц	250
5	Хөдөлгүүрийн чадал, кВт	110-132
6	Жин, тн	54.5
7	Овор хэмжээ, мм	3200x3050x2950

Чичиргээт шигшүүр. Шигшүүр нь 25, 60 мм ширхэглэлээр ангилж, эрчим хүчний нүүрсийг ялгаж, -25 мм-ээс доош ширхэглэлтэй эрчим хүчний нүүрсийг станцуудад нийлүүлнэ. БНХАУ-ын Zhengzhou Great Wall Heavy Industry Machinery компанийн 2YZS1548 маркийн чичиргээт шигшүүрийг ашиглана.

Хүснэгт 27. Сонгосон шигшүүрийн техникийн үзүүлэлт

№	Загвар	2YZS1548
1	Шигшүүрийн торны хэмжээ, мм	4800x1500
2	Шигших тавцангийн тоо	2
3	Шигшүүрийн торны нүхний хэмжээ, /мм/	3-100
4	Ширхэглэлийн хамгийн том хэмжээ, /мм/	200
5	Бүтээмж, /тн/цаг/	200
6	Хөдөлгүүрийн чадал, /квт/	15
7	Жин /тн/	5.35
8	Овор хэмжээ, /мм/	5740x2180x1220

1, 2-р конвейер: Хятад улсын Zhengyuan үйлдвэрийн TD-75 маркийн 1,800 мм, 800 мм өргөнтэй туузан конвейрийг ашиглана.

Хүснэгт 28. Туузан конвейерийн техникийн үзүүлэлт

№	Марк	TD-75
1	Бүтээмж, тн/ц	544 хүртэл
2	Туузны өргөн, мм	1800, 800
3	Дамжуулах өнхрүүлгийн диаметр, мм	320
4	Хөдөлгүүрийн чадал, кВт	3~100
5	Тулах өнхрүүлгийн диаметр, мм	159
6	Конвейерийн туузны хурд, м/с	1.25

Овоолго үүсгэгч конвейер: ОХУ-ын Мельмаш үйлдвэрийн 650 мм өргөнтэй овоолго үүсгэгч хөдөлгөөнт конвейрийг ашиглана.

Зураг 5. Овоолго үүсгэгч конвейер



Хүснэгт 29. Туузан конвейерийн техникийн үзүүлэлт

№	Марк	Стакер КЛ(С)-650-25
---	------	---------------------

1	Бүтээмж, тн/ц	450 хүртэл
2	Туузны өргөн, мм	650
3	Асгалтын өндөр, м	7.7
4	Хөдөлгүүрийн чадал, кВт	11
5	Конвейерийн туузны хурд, м/с	1.6
6	Шаардлагатай тоо	3

1.2. Дэд бүтэц

1.2.1 Уурхайн засвар, техникийн үйлчилгээ

Уурхайн засвар, техникийн үйлчилгээний дэд бүтэц нь уулын механик тоног төхөөрөмж, авто тээврийн болон нүүрс бутлан, ангилах хэсгийн тоног төхөөрөмжийн найдвартай ажиллагааг хангахын тулд урсгал засвар, техникийн үзлэг, үйлчилгээ хийхийн зэрэгцээ засвар ашиглалтын хэрэгцээний төрөл бүрийн материал, сэлбэг хэрэгсэл, түлш, тос зэргийг хүлээн авч хадгалах, тавьж олгох зориулалттай болно. Засвар, техникийн үйлчилгээний ажлын зохион байгуулалтын энэхүү үндэслэл нь засварын агрегат, зангилгааны аргыг хэрэглэн уулын механик тоног төхөөрөмж, тээврийн болон бусад тоног төхөөрөмжийн төлөвлөгөөт урьдчилан сэргийлэх засварын систем юм. Уурхай дээр 60х18 м харьцаатай 1,080 м² талбайтай засварын газар бий.

Уулын механик тоног төхөөрөмж, тээврийн болон бусад тоног төхөөрөмжийн агрегатын их засвар, томоохон хэмжээний урсгал засвар, зарим нарийн төвөгтэй эд ангийг сэргээх, засвар зэрэг ажлыг тухайн тоног төхөөрөмжийг үйлдвэрлэж нийлүүлсэн компанийн засварын газар болон техникийн зохих түвшинд тоноглогдсон, дагнасан засварын газар, байгууллагад гүйцэтгүүлнэ.

1.2.2. Уурхайн ус хангамж

Ундны усны хэрэглээг Бургастайн голоос зөөвөрлөж хэрэглэнэ. Байгалийн нөөц ашигласны төлбөрийн тухай хуулийн 20.1.1 дэх зүйл болон Засгийн газрын 2011 оны 302 дугаар тогтоолын 1-р хавсралт, Засгийн газрын 2013 оны 326-р тогтоолын 1-р хавсралтыг үндэслэн ус төлбөрийг тооцлоо. Усны үнэлгээ (Газрын гадарга): 1,195 төг/м³, ундны хэрэглээнд 0.7, Усны нөөц ашигласны төлбөрийн хэмжээг ундны усанд 0% байхаар тооцлоо.

Хүснэгт 30. Усны хэрэглээ, төлбөрийн дүн

№	Хэрэглэгч	2026 он
1	Хүн амын унд, ахуйн зориулалтаар ашигласан хэрэглээ, м3	231
	Зардлын дүн, мян.төг	0

1.2.3. Уурхайн барилга, байгууламж

Хар тарвагатайн уурхайн хувьд гадаргуугийн үйлдвэрлэлийн барилга, байгууламжийн ерөнхий төлөвлөлтийг зохих стандартын дагуу барьж байгуулсан. “Хар тарвагатай” ХК-ийн эзэмшилд байдаг уурхайн барилга, байгууламжийг хүснэгтэд үзүүлэв.

Хүснэгт 31. Уурхайн барилга, байгууламж

д/д	Барилга, байгууламжийн нэр	Тоо ширхэг
1	Уурхайн оффис, м ²	1
2	Дизель станцын байр	1
3	Уурын зуух	1
4	Ажилчдын орон сууц	1

5	ТБ-ын болон тэсрэх материалын агуулах	1
6	Автограж	1
7	Засварын газар	1
8	Хоолны газар	1
9	Пүүний барилга	1
10	Авто пүү	1
11	Агуулахын зориулалттай чингэлэг	1
12	Төмөр бетон хашаа, ил зогсоол	1

1.2.4. Цахилгаан хангамж

Уурхайн цахилгаан хэрэглэгчид

Уурхайн нүүрс бутлан, ангилах хэсэгт хацарт бутлуур, тэжээгүүр, шигшүүр, туузан тээвэрлэгч, овоолго үүсгэгч конвейрууд зэрэг хэрэглэгчдээс гадна уурхайн ажилчдын байр, хоолны газар, электрон пүү, засварын газар зэрэг цахилгаан хэрэглэгчидтэй байх бөгөөд эдгээр хэрэглэгчид нь 0.4 кВ-ын нам хүчдэлийн цахилгаан эрчим хүчээр хангагдана.

Уурхайн гэрэлтүүлэг: Уурхайн нүүрс бутлан, ангилах хэсгийн талбай, уурхайн ажилчдын байр, цайны газар, ШТС-ын, засварын газрын ойр орчмын ажлын талбайг нарны батеррей бүхий гэрэлтүүлэгчүүдээр гэрэлтүүлнэ.

Уурхайн цахилгааны ачааллын тооцоо: Уурхайн цахилгааны ачааллын тооцоо түүний үр дүнг хүснэгтэд үзүүлэв.

Хүснэгт 32. Уурхайн цахилгааны ачааллын тооцоо, түүний үр дүн

№	Хэрэглэгчийн нэр	Тоо	Рном, кВт	ΣРном, кВт	Кх	cosφ _г	tgφ _г	Р _г , кВт	Q _г , кВАр	Цахилгаан зарцуулалт, кВт/жил
А. Нүүрс бутлан, ангилах хэсэг										
1	Хацарт бутлуур	1	120	120	0.89	0.8	0.75	106.80	80.10	96,120
2	Тэжээгүүр	1	22	22	0.78	0.78	0.8	17.16	13.73	16,476
3	Чичиргээт шигшүүр	1	15	15	0.76	0.8	0.75	11.40	8.55	10,260
4	Туузан конвейер, 31м	1	11	11	0.76	0.76	0.85	8.36	7.11	8,532
5	Туузан конвейер, 6.5м	1	5.5	5.5	0.75	0.75	0.88	4.13	3.63	4,356
6	Овоолго үүсгэгч конвейер	3	11	33	0.8	0.78	0.8	26.40	21.12	25,344
	Дүн			206.5				174.25	134.23	161,192
	Тооцогдоогүй хэрэглэгчид (10%)							17.42	13.42	3,878
	Дүн							191.67	147.66	177,192
Б. Уурхайн ажилчдын түр байр, хоолны газар										
1	Уурхайн ажилчдын байр, хоолны газар, электрон пүү	1	30	30	0.78	0.86	0.59	23.40	13.81	3,878
2	Засварын газар	1	20	20	0.8	0.75	0.88	16.00	14.08	2,471
	Дүн							39.40	27.89	6,349
	Тооцогдоогүй хэрэглэгчид (10%)							3.94	2.79	494
	Дүн/							43.34	30.67	6,843
	Нийт дүн/							235.01	178.33	184,035

Тооцооноос харахад уурхайн нийт актив цахилгааны ачаалал нь 235.01 кВт байна.

1.2.5. Дизель цахилгаан үүсгэврийн тооцоо, сонголт

Уурхайн нүүрс бутлан, ангилах хэсгийн тооцооны бүрэн цахилгаан ачааллыг олж.

$$S_T = \sqrt{(\sum P_T)^2 + (\sum Q_T)^2} = \sqrt{191.67^2 + 147.66^2} = 241.95 \text{ кВА}$$

Тооцоогоор гарсан актив цахилгааны ачаалал 191.67 кВт, бүрэн цахилгаан ачаалал 241.95 кВА зэргийг үндэслэн CAT-GER-102 загварын 240 кВт актив ба 300 кВА бүрэн чадалтай 3 фазын 400 Вольтын хүчдэл гаргадаг цахилгааны үүсгэврийг ашиглана.

Уурхайн ажилчдын байр, хоолны газар, засварын газар зэрэг хэрэглэгчдийн тооцооны бүрэн цахилгааны ачааллыг олж.

$$S_T = \sqrt{(\sum P_T)^2 + (\sum Q_T)^2} = \sqrt{43.34^2 + 30.67^2} = 53.09 \text{ кВА}$$

Тооцоогоор гарсан актив цахилгааны ачаалал 43.34 кВт, бүрэн цахилгааны ачаалал 53.09 кВА зэргийг үндэслэн CAT-GER-40 загварын 70.5 кВт чадалтай 3 фазын 400 Вольтын хүчдэл гаргадаг дизель цахилгааны үүсгэврийг ашиглана.

1.3. Эдийн засгийн тооцоо

Хөрөнгө оруулалт: Ашиглалтын жилд хөрөнгө оруулалт хийгдэхгүй.

Хүснэгт 33. Борлуулалтын орлогын тооцоо

№	Үзүүлэлт	Хэмжих нэгж	Ашиглалтын жил
			2026
1	Нүүрс борлуулах нүүрсний хэмжээ	мян.тн	100.00
2	Нүүрс борлуулах үнэ	төг/тн	39,125
3	Борлуулалтын орлого	сая төг	3,912.5

1.3.1. Үйлдвэрлэл, үйл ажиллагааны зардал

Уурхайн үйлдвэрлэл, үйл ажиллагааны зардлыг тооцохдоо тухайн нэр төрөл, төрөл зүйлээр нь ангилан хамааруулан зардал бүрийг уурхайн ажиллах хугацаа, ажлын хэмжээтэй нь уялдуулан нарийвчлан тооцсон болно. Мөн Монгол Улсын хууль, дүрэм журмын дагуу уурхайн үйл ажиллагаагаа явуулахтай холбогдох гарах татвар, төлбөрийг тооцсон. Хөрс хуулалт, нүүрс олборлолт болон тээвэрлэлт явуулахтай холбогдон гарах зардлуудыг нэгтгэн үйлдвэрлэлийн зардалд дараах байдлаар бүлэглэн, зардлыг тусгалаа.

Хүснэгт 34. Нийт үйлдвэрлэл, үйл ажиллагааны зардлын нэгтгэл, мянган төгрөг

№	Зардлын утга	2025 он
1	Цалин хөлсний зардал	282.45
2	Үндсэн хөрөнгийн элэгдэл хорогдлын шимтгэл	469.0
3	Тэсэлгээний зардал	9.5
4	Машин техник, тоног төхөөрөмжийн сэлбэг, материалын зардал	1,230.5
5	Түлш, тослох материалын зардал	683.62
6	Тээвэр зардал	216.4
7	Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн зардал	33.0
8	Байгаль орчны менежментийн зардал	7.0
9	Хандив	110.0
10	Бусад тооцогдоогүй зардал	75.0
11	Татвар төлбөрийн зардал	550.1
	Нийт зардал	3,666.57

Хар тарвагатайн чулуун нүүрсний ордыг ил уурхайг ашиглахад жилд 3.66 тэрбум орчим төгрөгийн нийт үйлдвэрлэл, үйл ажиллагаа, татвар, төлбөрийн зардал гарахаар байна.

1.3.2.Үр ашиг

Ашиглалтын 2026 онд борлуулалтын орлого 4,983.98 сая төгрөг олж, нийт үйлдвэрлэл, үйл ажиллагааны зардалд 4,769.81 сая төгрөг зарцуулахаар тооцоод байна. Аж ахуйн нэгжийн орлогын албан татвар ногдуулсны дараах цэвэр ашиг 192.75 сая төгрөг байна.

БҮЛЭГ 2. ТӨСӨЛ ХЭРЭГЖИЖ БУЙ НУТГИЙН БАЙГАЛЬ ОРЧИН, НИЙГЭМ- ЭДИЙН ЗАСГИЙН ТӨЛӨВ БАЙДЛЫН ТОВЧ ТАНИЛЦУУЛГА

2.1. Уур амьсгал өнөөгийн төлөв байдал

Увс аймгийн Тариалан сумын нутаг нь уур амьсгалын мужлалын I бүсийн 2-р мужид хамрагдах бөгөөд энэ хэв шинжид чийглэг зэврүүн зунтай, хахир өвөлтэй уур амьсгалын төлөв илэрдэг [Үндэсний атлас 2009]. Энэ муж нь хуурай сэрүүвтэр, хур тунадас ихтэй зуны улиралтай бөгөөд голын хөндийн нам дор газар болон агаарын их даралтын мужтай холбоотойгоор нэн хахир хүйтэн өвөлтэй. Агаарын жилийн дундаж температур нь $(-5) ^\circ\text{C}$, I сарын агаарын дундаж температур нь -32°C , VII сарын агаарын дундаж температур нь 24°C байна. Хур тунадасны жилийн дундаж хэмжээ нь 300мм байна. Тогтвортой цасан бүрхүүл X сарын 1 түүнээс эрт тогтож, II сарын 10-ээс эхэлж, хайлж эхэлнэ. Нийт 140-с их хоногоор цасан бүрхүүл тогтоно. Дундаж зузаан нь 15 см. Хур тунадасны хэмжээг сараар харьцуулан үзэхэд VII ба VIII сард хамгийн их байдаг.

Жилийн дундаж салхины дундаж хурд нь 2-4 м/с харин хамгийн их хурд нь 30 м/с хүрнэ. 1-р сарын дундаж салхины дундаж хурд нь 0-2 м/с ба хамгийн их хурд нь 10 м/с байдаг. 7-р сарын дундаж салхины дундаж хурд нь 2-4 м/с, хамгийн их хурд нь 10 м/с байна. Судалгааны бүс нутаг нь мөнх цэвдгийн тархалтын хувьд уулархаг бүс нутгийн ам хөндийн олон жилийн цэвдэгт чулуулаг үргэлжлэн тархах, улирлын цэвдэг чулуулаг бүхий мужид харьяалагдана. Цэвдэгт хөрсний хувьд жилийн дундаж температур нь $0(-2) ^\circ\text{C}$, цэвдгийн зузаан нь 100-аас доош метр байна. Уур амьсгалын хэв шинжээс шалтгаалан хөрсөн бүрхэвчид улирлын хөлдөлт гэсэлтийн нөлөө болон ам хөндийн системд цэвдгийн бөөрөг, дов үүснэ.

2.2. Агаарын чанар өнөөгийн төлөв байдал

Уул уурхайн олборлолтын аргууд бүгд агаарын чанарт нөлөөлөл үзүүлдэг. Агаар дахь тоосны жижиг хэсгүүд ил уурхайн талбайд хөрс чулуулаг хуулах, бүтээгдэхүүн олборлох тэдгээрийг зөөх, хадгалах болон буцаан зөөх явцад бий болно. Хөрсийг хуулахад ургамлан нөмрөг мөн адил хуулагдах бөгөөд ингэснээр хөрсийг цаг агаарын нөхцөлд өртөмтгий болгож, тоосны жижиг хэсгүүдийг салхины элэгдэл, замын хөдөлгөөн зэргийн нөлөөлөлд хялбар өртөн, орчны агаарын тархах шалтгаан болдог. Хар тарвагатай ХК-ийн уурхайн үйл ажиллагааны явцад техник хэрэгслийн нөлөөгөөр тоосжилт үүснэ. 2021 оны 8 сард Увс аймгийн ус цаг уур, орчны шинжилгээний төвийн байгаль орчны шинжилгээний лабораториор шинжилгээ хийлгэхэд стандартаас давсан үзүүлэлт байхгүй байна.

2.3. Газрын гадарга, хэвлий өнөөгийн төлөв байдал

Уурхай нь одоогийн байдлаар уурхайн урт 890 м, өргөн 397 м бөгөөд 35.4 га талбайд 42 м хүртэлх гүнтэйгээр хайгуулын I-III шугамын хооронд олборлолтын ажил явагдаж байна. Овоолго геологийн тогтцоос нь хамааран хөрсний гадаад овоолгод байгуулагдана. Уурхайн ашиглалтын эцсийн байдлын хил хязгаар доторх геологийн нөөц болон хөрс хуулалтын тооцооны хүснэгтээс харахад ил уурхайн хил хязгаар дотор геологийн үлдэгдэл 207335.9 мян.тн нүүрсний нөөц, 3256.71 мян.м3 хөрс ТЭЗҮ-д тооцоологдсон байна. Ашиглалтын 10 лах жилд урд талаараа хайгуулын шугам 1 хойд талаараа хайгуулын 4 хүртэл, 687.5 м урттай, 246.1 өргөнтэй, 16.9 га талбайг хамарч 2400 м түвшин хүртэл ашиглалтын ажил явуулахаар төлөвлөсөн байна.

2.4. Төслийн талбайн гадаргын усны төлөв байдал

Хартарвагатайн чулуун нүүрсний орд нь Намирийн голын градену зүүн хойноосоо баруун урагш нь сунасан бараг төв хэсэгт байрлана. Намирийн голын Грабен нь дотроо 4 жижиг хагарлаар хуваагдаж 5 блок болсон. Нарийвчилсан хайгуул хийгдсэн талбай нь зүүн хойш болон

баруун хойш нь чиглэсэн тектоник хоёр хагарлаар баруун, зүүн, хойт гэсэн 3 блокт хуваагдаж байна. Талбайн төвөөр зүүн хойш чиглэсэн хагарлаар уг талбай нь 2 хэсэгт хуваагдаж урд хэсэг нь хойт хэсгээсээ 50 м өндөрт өргөгджээ. Өмнөд хэсэг нь хайгуулын 2-3 дугаар шугамын хооронд байгаа хагарлаар мөн 2 хуваагдаж байгаа бөгөөд зүүн тал нь баруун талаасаа 40 м өргөгджээ. Нүүрсний орд орчмын газар нь тектоник хагарлаас гадна, тектоник атриажилд нэлээд хэмжээгээр орсон байна.

Хартарвагатайн орд нь 80-85 м зузаантай нүүрсний нэг давхаргаас бүрдэнэ. Хайгуул хийгдсэн талбайн хэмжээнд нүүрст давхаргыг агуулсан 3 синклиналь атрия тогтоогдсон байна. Эдгээр нь уг талбай дээр байгаа 2 хагарлын нөлөөгөөр нэлээд нийлмэл тогтоцтой болсон. Нүүрст давхаргын уналын өнцөг нь 40-55°. Нүүрст давхарга нь харьцангуй энгийн тогтоцтой нэгэн төрлийн нүүрслэг хэсгээс бүрдэнэ. Нүүрст давхаргын дунд болон доод хэсгээр 2-4 м болон 0.1-0.2 м зузаан шаварлаг занар болон элсэн чулууны 2-4 ширхэг нимгэн үеүд байна. Тус ордын нүүрс нь хувирлын зэргээрээ Д маркийн чулуун нүүрсний ангилалд багтаж байна. Нүүрс нь өгөршилд өртөөгүй нягт, бат бэх, хагас гялгатай өнцөглөг хагаралтай нэгэн төрлийн жигд бүтэцтэй хар саарал, хар өнгөтэй. Нүүрсний ордод гидрогеологийн судалгааг тусгайд нь хийгээгүй хайгуулын явцад цооногуудад шавхалт хийж газрын доорх усны түвшинг тогтоосон. Хайгуул хийгдсэн талбайн хойт хэсэгт газрын доорх усны түвшин 80-100 м, урд хэсэгт 20 орчим метрт байна. Энэ нь газрын доорх усны түвшин урдаасаа хойш нэлээд налуу болохыг харуулж байна. Нүүрсний нөөцийн ихэнх хэсэг нь газрын доорх уснаас дээш түвшинд орших тул олборлолтонд усны нөлөөлөл бараг байхгүй.¹

Хар тарвагатайн нүүрсний уурхайн ойролцоох газар нутаг нь Төв Азийн гадагш урсгалгүй ай сав газарт багтдаг. Энэ хэсэгт Бургастайн гол болон түүний салбар олон жижиг

гол горхитой. Уурхай нь Бургастайн голын баруун цутгал болох жижиг горхины зүүн эргийг даган газраас 2-3 км-ын зайд оршдог. Одоогийн байдлаар уурхайн ажилчдын ундны усыг Бургастайн голоос авто тээврээр зөөж хэрэглэдэг. Уурхайн талбайн нөлөөллийн бүсэд Бургалтайн голын эх Баруун салаа голын баруун цутгал байрлах голын хөндийд байрлана. Хар тарвагатайн уурхай байрлаж буй Хархираа уулын системд мөнх цас байхгүй боловч цэвдэгт хөрсний гэсэлтийн нөлөөгөөр дулааны улиралд урсдаг булаг үүсэх боловч уурхайн үйл ажиллагааны нөлөөгөөр ширгэсэн байгаа бол налуугийн нөлөөгөөр зуны хур борооны усаар үүсэх гадаргуугийн урсац гуу жалга ихээр үүсгэх бол уурхайн нөлөөллийн бүсийн орчимд талхагдлын нөлөөгөөр гадаргын нил угаагдал үүссэн шинжтэй байна.

1962-1964 онд ЗХУ/хуучин нэрээр/-ын Геологийн экспедицийн хийсэн ордын хайгуулын ажлын үед газрын доорх усны байршил, түвшинг тогтоох зорилгоор 15 цооног өрөмдсөн байна. Ордын нарийвчилсан хайгуул хийгдсэн талбайн нүүрс нь атираажилтанд орсон нэг давхарга, гурван синклиналь тогтоцоос бүрдэнэ. Ордын нүүрсний давхарга нь энгийн тогтоцтой зузаан нь 80-85м ба нүүрсний давхарга дотор 2-4 үетэй, 2-4м, 0.1-0.2м зузаан чулуулгийн үенцэртэй. Нүүрсний давхарга нь 1-2м дөрөвдөгчийн хурдсаар хучигдсан байна. Орд газрын гидрогеологийн нөхцөл нь ил аргаар ашиглахад тохиромжтой, нүүрсний нөөцийн ихэнх нь газрын доорх усны түвшингээс дээш оршиж байна. Хайгуул хийгдсэн талбайн хойд хэсэгт газрын доорх усны төвшин 80-100м, урд хэсэгт 20 метрт байсан байна. Энэ нь газрын доорх усны төвшин хойноосоо урагш нэлээд налуу болохыг харуулж байна.

Нүүрсний нөөцийн ихэнх хэсэг нь газрын доорх уснаас дээш орших тул олборлолтод усны нөлөөлөл бараг байхгүй ус таталт, ус шүүрүүлэлтийн ажил маш бага байхаар тогтоогджээ. Газрын доорх усны гадарга нь харьцангуй эгц уналттай буй 100-200м зайд 10м-ээр доошилж

¹ Уул уурхайн хүрээлэн ТЭЗҮ 9-р хуудас

байна. Газрын доорх усны гадаргын эгц унал нь шүүрэлтийн итгэлцүүр маш бага болохыг харуулсан байна. Нөгөө талаас үйлдвэрлэлийн зэргээр тогтоогдсон нөөц бүхий талбайн хувьд газрын доорх усны илэрч буй гүн нь 60-80м байгаа нь нүүрст үе нь газрын доорх уст үеийн дээр байрлах гидрогеологийн нөхцөлд оршиж буйг харуулж байна.

2.5. Хөрсөн бүрхэвч өнөөгийн төлөв байдал:

Увс аймгийн Тариалан сумын нутагт, Монгол Алтайн нурууны салбар Хархираа-Түргэний нурууны Гурван хороо уул (3227.8м) уулын өвөр хажуугийн системд “Хар тарвагатай” ХК-ийн MV-009950/13.96 га/, MV-009951/100.88 га/, MV-011923/682.76 га/, MV-001366/24.86 га/ тоот тусгай зөвшөөрөл бүхий 4-н талбайгаас бүрдэх 822.46га талбай эзлэн байршдаг. Байгаль газарзүйн нөхцөлийн хувьд орой хэсгээрээ хадан гарш бүхий 2400-2800м орчим өндөртэй уулсын нарийн хавчиг ам хөндийн хамран байрших тул уулын хээрийн нимгэн сайргархаг, хар хүрэн, ам хөндий дагасан нугархаг хүрэн, нуга-намгийн зэрэг бага зайд огцом шилждэг онцлог бүхий хөрсөн бүрхэвч бүрэлдэн тогтдог. Нөгөөтээгүүр өндөр уулсын системд, огцом налуу бүхий хажуу, хавчиг ам хөндий бүхий уулсын системд байрлах учир налуугийн зөөгдөл, гадаргын угаагдал, уурхайн ашиглалтын эрчим, хугацаа зэргээс шалтгаалан, уурхайн нөлөөлөл хөрсөн бүрхэвчинд тодорхой хэмжээний нөлөө үзүүлдэг шинжтэй.

Иймд уулархаг нутагт байрлах Хар Тарвагатайн нүүрсний уурхайн талбайд тархсан зонхилох хэв шинжийн хөрсний тархалтын үнэлэх, түүний хими, физик шинж чанарыг тодорхойлох, хөрсний эвдрэл, бохирдлын өнөөгийн төлөв байдлыг үнэлэх, уурхайн үйл ажиллагааны зүгээс хөрсөн бүрхэвчинд үзүүлэх сөрөг нөлөөллийг илрүүлэх, түүнийг бууруулах, сааруулах үйл ажиллагааг төлөвлөх зорилгоор хөрсөн бүрхэвчийн суурь судалгаа хийж гүйцэтгэлээ.

Увс аймгийн Тариалан сумын нутагт, Хархираа уулын системд байрлах нь хөрс-газарзүйн мужлалаар Төв Азийн хөрс-био уур амьсгалын их мужийн Говийн мужийн Өндрийн бүсшилийн хэв шинж бүхий Монгол Алтайн хэв шинж бүхий Хархираа-Түргэний 50-р тойрогт багтана [Үндэсний атлас, 2009]. Тус бүсэд уулархаг, өндөр уулс бүхий нутгаар өндөр уулын ба уулын тундрийн, өндөр уулын хээрийн бүдүүн ялзмагт хөрс тархсан бөгөөд энэ төрлийн хөрс нь уулс-тайгын бүсэд уулын ар хажуугийн дунд ба доод хэсгээр, мөн өвөр хажуугийн системд элбэг тохиолдоно. Ойн ширэгт хөрс уулс-ойт хээрийн бүсэд уулын ар хажуугаар 1300-1400 метрээс 1900-2000 метр хүртэлх үнэмлэхүй өндөрт өвслөг бүрхэвч бүхий нугархаг бүсэд голчлон тархана. Уулын ам хөндийд үүссэн цэвдгийн болон хур тунадасны усаар угаагдах чийглэг бүсүүдэд нуга- намгийн, намгийн цэвдэгт хөрстэй.

Хар тарвагатайн нүүрсний уурхайн талбайд уулын хээрийн нимгэн ялзмагт давхарга бүхий сайр чулуурхаг хүрэн хөрс, сайргархаг, нугархаг хар хүрэн хөрс, хөнгөн шавранцар бүтэцтэй, зузаавтар хар хүрэн, ам хөндийн хүрэн шороон хөрс, аллювийн нугын болон хужирлаг хөрсний хэв шинжүүд голчлон тархана.

2.6. Ургамлан бүрхэвч өнөөгийн төлөв байдал

Увс аймгийн Тариалан сумын нутаг болон Хархираа-Түргэний уулсын бүс нутаг нь ургамал-газарзүйн мужлалын хувьд Евроазийн шилмүүст ой, нуга хээрийн их мужийн хуурайдуу хэв шинжийн төв Азийн хэв шинжийн Хархираа-Түргэний 31-р тойргийн нутагт байрлана. Тус тойрогт өндөр уулын тундр, хагт, хөвдөт хэв шинжийн ургамал зонхилон тархах бөгөөд Түргэний уулсын системд улалжит, бушилз-улалжит хэв шинжийн ургамал уулын орой хэсгийн сарьдаг орчмын тохиох бол уулын ам хөндий, бэл орчмын нам дор газруудаар өндөр уулын хээртэй хосолсон бушилзат, улалжит хэв шинжийн ургамалшил зонхилно.

Нүүрсний уурхай орчмын ургамал бүрхэвчид . Дундаж өндөр уулын Ботууль-алаг өвст, Жижиг дэгнүүлт үетэн-алаг өвст бэлчээрт бүлгэмдэл, Уул хоорондын Үетэн –улалж-алаг өвст бэлчээрт бүлгэмдэл, голын хөндийн Улалж-үетэн-алаг өвст довонтой бэлчээр тархаж байна.

2.7. Төслийн талбай орчмын амьтны аймаг

Мөлхөгчид. Монгол орны мөлхөгчдийн суурь эх сурвалжуудад (Мөнхбаяр 2010, Тэрбиш 2006) хайгуулын талбай нь гүрвэлүүдээс Цоохор хонин гүрвэл *Phrynoscephalus versicolor*, Могой гүрвэл *Eremias multiocellata*, говийн гүрвэл *Eremias przewalskii*, могойнуудаас Рашааны могой *Elaphe dione*, бамбай хоншоорт могой *Gloydus halys*гэсэн зүйлүүдийн тархац нутаг болох нь тодорхой байна. 2017 оны 8 дугаар сарын судалгаагаар дээрх зүйлүүдээс цоохор хонин гүрвэл, могой гүрвэл тэмдэглэгдсэн ба цоохор хонин гүрвэл нь харьцангуй өргөн тархалттай болох нь ажиглагдсан. **Махчин шувууд.** Төслийн талбайн хэмжээнд махчин шувуудаас сохор элээ *Milvus migrans*, ойн сар *Buteo buteo*, шилийн сар *Buteo hemilasius*, цармын бүргэд *Aquila chrysaetos*, нөмрөг тас *Aegypius monachus*, зээрд шонхор *Falco naumanni*, начин шонхор *Falco tinnunculus* 7 зүйл бүртгэгдэв.

Хөхтөн. Жижиг хөхтнөөс уулархаг газартаа Монгол тарвага нь *Marmota sibirica*, бараан хэрэм *Sciurus vulgaris*, урт сүүлт зурам *Spermophilus undulates*, тавшигар барагчин *Alticola strelzowi*, хадны барагчин *Alticola semicanus*, бараан оготно *Microtus arvalis*, хэргэлзий оготно *Microtus gregalis*, мэхээрч оготно *Microtus oeconomus*, азийн хулгана *Apodemus peninsulae*, тагийн огдой *Ochotona alpine*, дагуур огдой *Ochotona dauurica*, үхэр огдой *Ochotona pallasii*, цагаан үен *Mustela ermine*, өмхий хүрэн *Mustela eversmannii*; Говь хээрийн хөндий тал, ус намгархаг газартаа болзлог зурам *Spermophilus erythrogenys*, говийн алагдаага *Allactaga bullata*, шивэр алагдаага *Allactaga sibirica*, таван хуруут атигдаахай *Cardiocranius paradoxus*, элсч савагдаахай *Dipus sagittal*, монгол даахай *Stylodipus andrewsi*, цомч шишүүхэй *Allocricetulus curtatus*, хөх шишүүхэй *Cricetulus barabensis*, сүүллэг шишүүхэй *Cricetulus longicaudatus*, орог зусаг *Phodopus campbelli*, элсний зусаг *Phodopus roborovskii*, сохдой оготно *Ellobius tancrei*, овын хөх оготно *Lagurus lagurus*, шаргал чичүүл *Meriones meridianus*, хул чичүүл *Meriones unguiculatus*, бор туулай *Lepus tolai*, дэлдэн зараа *Hemiechinus auritus*, малтаахай *Crociodura sibirica*, усч гэрэлзгэнэ *Neomys fodiens*, өөдсөн атаахай *Sorex minutissimus*, цармын атаахай *Sorex tundrensis*, алтайн чацуулин *Talpa altaica*, умардын сармаахай *Eptesicus nilsoni*, уссаг багваахай *Myotis daubentonii*, сахалт багваахай *Myotis mystacinus*, жижиг соотон багваахай *Plecotus auritus*, буурал сармаахай *Vespertilio murinus*, хотны үен *Mustela nivalis*, эрээн хүрнэ *Vormela peregusna* оршин амьдарна. Хээрийн судалгаа хийгдсэн 2017 оны 8 дугаар сарын дунд үед хур тунадастай, салхитай бүүдрэг зэврүүн өдрүүд таарсан тул жижиг хөхтний идэвх сул байв. Шаргал чичүүл, бозлог зурам, сохдой оготно, бор туулай, тарвага, огдой гэсэн цөөвтөр зүйл ажиглагдсан.

БҮЛЭГ 3. ТӨСЛИЙН ГОЛ БА БОЛЗОШГҮЙ СӨРӨГ НӨЛӨӨЛЛИЙН ТОВЧ ТОДОРХОЙЛОЛТ

Увс аймгийн Тариалан сумын нутаг дэвсгэрт байрлах “Хар тарвагатай” ХК-ийн нүүрсний ордыг ил аргаар ашиглах төслийн байгаль орчны бүрэлдэхүүн хэсгүүдэд нөлөөлөх нөлөөллийн хэлбэрийг шууд, шууд бус, нөлөөллийн үргэлжлэх хугацааг богино болон урт хугацааны, тэрчлэн эрчимшлийн хувьд хүчтэй, дунд болон бага зэрэг гэхчлэн ангилан магадлан жагсаалт гаргаж доор хүснэгтэд харууллаа.

Хүснэгт 35. Төслийн үйл ажиллагаанаас байгаль орчинд үзүүлж болзошгүй нөлөөллийн хэлбэр, үргэлжлэх хугацаа, эрчим

Байгаль орчны үзүүлэлтүүд	Шууд	Шууд бус	Өөрөө зохицуулагдах	Богино хугацааны	Урт хугацааны	Буцаж нөлөөлөх	Буцалтгүй нөлөөлөх	Хүчтэй	Дунд зэрэг	Бага зэрэг
1.Байгалийн экосистемийн өөрчлөлт										
Газрын доорх урсцын өөрчлөлт		+			+		+		+	
Гадаргын усны урсцын өөрчлөлт		+			+		+			+
Ургамлын бүтцийн өөрчлөлт	+				+		+			+
Хөрсний элэгдэл, эвдрэл үүсэх	+				+		+		+	
Хөрсний үржил шим буурч цөлжилт нэмэгдэх		+			+	+			+	
Хөрсний механик эвдрэлтэй холбогдон агаарт техноген тоосжилт үүсэх	+			+		+			+	
Тоосжилтын нөлөөгөөр орчны бүс нутгийн хөрсний гадарга дээр нунтаг шорооны хуримтлал үүсэж ургамал болон хөрсний өсөж хөгжих орчин өөрчлөгдөх		+			+	+				+
Хөрсний бүтцэд өөрчлөлт орж, нийт эзлэхүүнд байх эрдэсжилт нэмэгдэн үржил шим (ялзмаг, фосфор, кали гэх мэт) багасах	+				+		+			+
Геологийн тогтцын өөрчлөлт		+			+		+		+	
Зэрлэг амьтдын амьдрах орон зай хумигдах		+			+		+			+
Уур амьсгалын (бичил) өөрчлөлт			+		+	+				+
2.Байгалийн нөөц, ашиглалт										
Газрын доорх нөөц баялаг багасах	+				+		+	+		
Бэлчээрийн байдал өөрчлөгдөх	+				+		+		+	
Хөрсний үржим шимт давхарга бүхий нөөц алга болох	+			+		+		+		
Эрдэс түүхий эдийн нөөц багасах	+				+		+		+	
Эрчим хүчний нөөц багасах		+			+		+		+	

3.Байгаль орчны чанарын өөрчлөлт										
Газрын доорх усны чанарын өөрчлөлт		+			+		+			+
Гадаргын усны чанарын өөрчлөлт			+	+		+				+
Агаарын бохирдол үүсгэх	+			+	+	+			+	
Хөрсний бохирдол, чанар өөрчлөгдөх		+			+		+			+
Хорт бодис усаар дамжин хүн ам, ан амьтанд нөлөөлөх	+			+		+			+	
Дуу чимээ, шуугианы нөлөө			+	+		+			+	
4.Байгалийн өнгө төрх, түүх соёлын дурсгалт зүйл, археологи, палеонтологийн олдвор										
Байгалийн үзэсгэлэнт төрх өөрчлөгдөх	+				+		+			+
Ландшафтын хэлбэр, өнгө өөрчлөгдөх	+				+		+		+	
Тусгай хамгаалалттай газар нутагт нөлөөлөх		+		+						+
Түүх соёлын дурсгалт зүйлд нөлөөлөх		+			+					+
Археологи, палеонтологийн олдворт нөлөөлөх		+			+					+
5.Эдийн засаг, нийгмийн асуудал										
Хувийн өмчийн болон татварын орлого өөрчлөгдөх	+				+		+	+		
Орон нутгийн орлого нэмэгдэх	+				+		+	+		
Ядуурлыг бууруулахад дэмжлэг болох	+			+			+		+	
Ажлын байр нэмэгдэх	+				+	+			+	
Улирлын чанартай эрэлт хэрэгцээ нэмэгдэх	+				+		+		+	
Хүн амын эрүүл мэндэд нөлөөлөх		+			+	+				+
Хөрсний механик эвдрэлтэй холбогдон агаарт тоосжилт үүсэж хүний амьсгалын замын эрхтэнд нөлөөлөл үзүүлэх		+			+	+				+
6.Бусад нөлөөлөл										
Хайгуулын үед шороон зам харилцаа, машин механизмын хөдөлгөөн шилжилтээс болж хөрс эвдрэх	+				+		+		+	
Аюулгүй ажиллагааны журмыг мөрдөөгүйгээс байгаль орчинд сөргөөр нөлөөлөх			+		+		+		+	
Барилгын ажлын хатуу, шингэн хаягдлаар байгаль орчин бохирдох	+			+		+				+
Дүн	19	14	4	9	28	13	21	4	17	16

БҮЛЭГ 4. БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТУХАЙН ЖИЛИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ ГОЛ ЗОРИЛТ, ХАМРАХ ХҮРЭЭ

“Хар тарвагатай” ХХК нь Байгаль орчин, аялал жуулчлалын сайдын 2019 оны 10 дүгээр сарын 29-ны өдрийн А/618 тоот тушаалаар шинэчлэн баталсан “Байгаль орчны менежментийн төлөвлөгөө боловсруулах, хянан батлах, тайлагнах журам”-ын дагуу Хар тарвагатайн чулуун нүүрсний ордын 2026 оны байгаль орчны менежментийн төлөвлөгөөг боловсрууллаа.

Тухайн жилийн байгаль орчны менежментийн төлөвлөгөө гэж Байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээний тухай хуулийн 9.8-д заасан төлөвлөгөөг ойлгоно. Ерөнхий үнэлгээ хийсэн байгууллагын хянаж баталсан тухайн жилийн байгаль орчны менежментийн төлөвлөгөө нь төслийн үйл ажиллагааг эхлүүлэх, үргэлжлүүлэхийг зөвшөөрсөн байгаль орчны үндсэн баримт бичиг болно.

Хар тарвагатай ХК-ийн Хар тарвагатайн чулуун нүүрсний ордыг ашиглах төслийн 2026 оны байгаль орчны менежментийн төлөвлөгөөний байгаль хамгаалах төлөвлөгөөнд байгалийн нөөц баялгийг ашиглах явцад байгаль орчныг доройтохоос урьдчилан сэргийлэх, сөрөг нөлөөллийг бууруулах, арилгах, үлдэгдэл нөлөөллийг дүйцүүлэн хамгаалах, нөхөн сэргээх, нүүлгэн шилжүүлэх, нөхөн олговор олгох, түүх соёлын өвийг хамгаалахтай холбогдсон арга хэмжээг тодорхойлон, шаардагдах хөрөнгө зардлыг тооцож, хариуцах этгээд, хэрэгжүүлэх хугацаа, баримтлах хууль, журам, аргачлал, стандартыг тодорхойлж тусгалаа.

Хар тарвагатай ХК-ийн Хар тарвагатайн чулуун нүүрсний ордын 2026 оны байгаль орчны менежментийн төлөвлөгөөний орчны хяналт шинжилгээний хөтөлбөрт байгаль орчны төлөв байдлын өөрчлөлт, сөрөг нөлөөллөөс урьдчилан сэргийлэх, арилгах, бууруулах арга хэмжээ үр дүнтэй байгаа эсэх, сөрөг нөлөөллийн эрчим, цар хэмжээ нь зөвшөөрөгдөх хэмжээнд байгаа эсэхийг тогтоох ажиглалт, хэмжилт, дээжлэлт хийх байршил, давтамж, хариуцах этгээд, шинжилгээний арга, шаардагдах зардлыг тооцож орууллаа.

Хар тарвагатай ХК-ийн Тарвагатай нүүрсний ордын 2026 оны байгаль орчны менежментийн төлөвлөгөөг байгаль хамгаалах хууль тогтоомж, байгаль орчны нөлөөллийн нарийвчилсан үнэлгээний үр дүн, батлагдсан байгаль орчны менежментийн төлөвлөгөө (5 жил)-нд үндэслэн боловсруулав.

БҮЛЭГ 5. СӨРӨГ НӨЛӨӨЛЛИЙГ БУУРУУЛАХ АРГА ХЭМЖЭЭНИЙ ТӨЛӨВЛӨГӨӨ

Дээр дурдсан болзошгүй гол сөрөг нөлөөллийг бууруулахын тулд дараах арга хэмжээг авч хэрэгжүүлэх шаардлагатай юм. Болзошгүй сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээг нөлөөлөлд өртөж болзошгүй бүрэлдэхүүн тус бүрээр нь ангилан тодорхойлов.

Сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээний төлөвлөгөөнд техник хэрэгслээс агаарт тархах хорт утааг бууруулах, тоосжилтийг бууруулах зорилгоор замын усалгааг хийх, мониторингийн цэгүүдэд хяналт хийж дээжлэлт хэмжилт хийх ажлуудыг тусгаж өгсөн. Энэхүү төсөл нь 97 жилийн хугацаанд хэрэгжих бөгөөд уурхай бүрэн хүчин чадлаараа ажиллах тохиолдолд 47 хүн ажиллах бөгөөд иймд ажилчдын эрүүл ахуйн шаардлагад нийцсэн мөн байгаль орчиндоо ээлтэй ариун цэврийн эрэгтэй эмэгтэй тусдаа бие засах газрыг барьж байгуулахаар төлөвлөсөн.

Хартарвагатайн нүүрсний ордыг авто-тээвэртэй ашиглалтын системээр ашиглана. Хартарвагатайн нүүрсийг уурхайн ашиглалтанд “Хар тарвагатай” ХК-д одоо хэрэглэж байгаа техник, тоног төхөөрөмжүүдийг цаашид үргэлжлүүлэн ашиглана. Уурхайн ашиглалтын 15 дахь жилээс хөрсний дотоод овоолго байгуулна. Уурхайгаас олборлосон нүүрсийг бутлан, ангилна. Иймд уурхайн олборлолтоос гарсан хөрсний овоолгуудыг салхины ноёлох чиглэлд хөндлөн байрлалтайгаар, үржил шимт хөрсний овоолгыг 5 м-ээс ихгүй өндөртэй, овоолгын тогтворжилтын өнцөг 18 градусаас ихгүй, оройн хэсгийг орчны гадаргын төрх байдалтай ойролцоо бөмбөгөрдүү байхаар байгуулахаар төлөвлөсөн. Энэхүү ажлын нийт зардалд **4298 320** төгрөг зарцуулахаар төлөвлөлөө.

Хүснэгт 36. Сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээний төлөвлөгөө

№	Гол болон болзошгүй сөрөг нөлөөллүүд	Сөрөг нөлөөллийг арилгах, бууруулах арга хэмжээ	Сөрөг нөлөөллийн хамрах хүрээ	Хэмж их нэгж	Нэгжийн зардал, төг	Тоо хэмжээ	Нийт зардал, төг	Хэрэгжүүлэх хугацаа, давтамж	Баримтлах эрх зүйн баримт бичиг
5.1. Агаарын чанарт үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээний төлөвлөгөө									
1	Агаарын хуурайшилттай холбоотойгоор тоосжилт үүсэх, үзэгдэх орчин хязгаарлагдах	Тээврийн болон уурхайн дотоод замыг услах	Уурхайн зам, тээвэрлэлтийн зам	Км		Хүснэгт 38-д задаргааг оруулав.	1 804 320	Бороо орсон өдрөөс бусад уурхай ажиллах өдөр бүр	-Агаарын ба агаарын бохирдлын төлбөрийн тухай хууль, -MNS4585:2007 (Агаарын чанар, Техникийн ерөнхий шаардлага)
2	Замын хөдөлгөөны аюулгүй байдал аваар осол гарч болзошгүй.	Тээвэрлэлтийн зам дагуу тэмдэг тэмдэглэгээ сайжруулах	Төв замаас уурхай хүртэл	1 км	30.000 төг	20	600.000	2026 оны 6-8 сард	

№	Гол болон болзошгүй сөрөг нөлөөллүүд	Сөрөг нөлөөллийг арилгах, бууруулах арга хэмжээ	Сөрөг нөлөөллийн хамрах хүрээ	Хэмж их нэгж	Нэгжийн зардал, төг	Тоо хэмжээ	Нийт зардал, төг	Хэрэгжүүлэх хугацаа, давтамж	Баримтлах эрх зүйн баримт бичиг
4	Аваар осол гарч болзошгүй, Тоосжилт үүсэх, үзэгдэх орчин хязгаарлагдах	Маршрутын бус замаар тээвэрлэлт хийхгүй байх	Уурхайн талбай			Үйл ажиллагааны зардалд тусгагдсан.		Өдөр бүр	-MNS3383:1982 (Агаар мандал, Бохирдлын эх үүсвэр, нөхцөл байдал ба тодорхойлолт) -MNS5885:2008 (Агаар бохирдуулагч бодисуудын хүлээн зөвшөөрөгдсөн концентрац, Техникийн ерөнхий шаардлага)
5	Аюулгүй байдал аваар осол гарч болзошгүй хэтрүүлэхгүй байх	Тээвэрлэлтийн явцад машин, техникийн даацыг хэтрүүлэхгүй байх	Уурхайн зам, тээвэрлэлтийн зам					Өдөр бүр	
6	Тоосжилтыг хэмжих	Агаарын чанарын хэмжилтийн багаж авах	Уурхайн талбай, тээвэрлэлтийн зам	ш	1200 000	1	1200 000	1 удаа	
5.2. Хөрсөн бүрхэвчид үзүүлэх нөлөөллийг бууруулах арга хэмжээний төлөвлөгөө									
7	Хөрсний үржил шимт алдагдах	Уурхайн олборлолтоос гарсан хөрсний овоолгуудыг салхины ноёлох чиглэлд хөндлөн байрлалтайгаар, үржил шимт хөрсний овоолгыг 5 м-ээс ихгүй	Шимт хөрсний овоолго	M2				Үйл ажиллагааны туршид	Хөрс хамгаалах, цөлжилтөөс сэргийлэх тухай хууль, Газрын тухай хууль

№	Гол болон болзошгүй сөрөг нөлөөллүүд	Сөрөг нөлөөллийг арилгах, бууруулах арга хэмжээ	Сөрөг нөлөөллийн хамрах хүрээ	Хэмж их нэгж	Нэгжийн зардал, төг	Тоо хэмжээ	Нийт зардал, төг	Хэрэгжүүлэх хугацаа, давтамж	Баримтлах эрх зүйн баримт бичиг
		өндөртэй, овоолгын тогтворжилтын өнцөг 18 градусаас ихгүй, оройн хэсгийг орчны гадаргын төрх байдалтай ойролцоо бөмбөгөрдүү байхаар байгуулах							MNS 4598:2011 Авто тээврийн хэрэгслийн техникийн байдалд тавих ерөнхий шаардлага MNS5914:2008
8	Хөсрий элэгдэл эвдрэл үүсэх	Үер, уснаас хамгаалах далан шуудуу байгуулах	Уурхайн талбай	-	-	-	194000	Жилд 1 удаа	Эвдэрсэн газрын нөхөн сэргээлтийн нэр томьёо, тодорхойлолт, MNS5915:2008
9	Олон салаа зам гаргаж, талхагдал үүсэх	Маршрутын бус замаар тээвэрлэлт хийхгүй байх	Уурхайн тээвэрлэлтийн зам, баяжуулах үйлдвэр, засварын төв	1	-	-	-	Үйл ажиллагааны турш	Уул уурхайн үйлдвэрлэлийн үйл ажиллагаагаар эвдэрсэн газрын ангилал MNS5917:2008 Уул уурхайн үйлдвэрийн үйл ажиллагаагаар эвдэрсэн газрын нөхөн сэргээлт Байгаль орчныг хамгаалах тухай

№	Гол болон болзошгүй сөрөг нөлөөллүүд	Сөрөг нөлөөллийг арилгах, бууруулах арга хэмжээ	Сөрөг нөлөөллийн хамрах хүрээ	Хэмж их нэгж	Нэгжийн зардал, төг	Тоо хэмжээ	Нийт зардал, төг	Хэрэгжүүлэх хугацаа, давтамж	Баримтлах эрх зүйн баримт бичиг
									хууль Газрын тухай хууль Усны тухай хууль Газрын хэвлийн тухай хууль Химийн хортой ба аюултай бодисын тухай хууль
5.3.Амьтны аймагт үзүүлэх нөлөөллийг бууруулах арга хэмжээний зөвлөмж									
10	Зэрлэг амьтны хууль бус ан ангуур нэмэгдэх, зүй бус хорогдол тоологдох	Ажилчид болон төсөлтэй холбоотойгоор төслийн талбайд ирэх хүмүүст хууль бус ан агнуурын тухай сануулга, өгч хууль тогтоомжийг танилцуулан ан агнуур хийлгэхгүй байх арга хэмжээ авах	Хууль бус ан ангуурын талаар ухуулга сурталчилгаа, гарын авлага материал тараах	Ш	1000	500 ш	500 000	Хаврын улиралд	Байгаль орчныг хамгаалах тухай хууль Амьтныг хамгаалах тухай хууль
	Нийт						4298 320		

Зам, талбайн тоосжилт дарах усны хэрэглээ

Уурхайн зам талбайн нөлөөлөлд өртөх зам талбайд тоосжилт дарах усалгааг салхи шуурга ихтэй 4-8 саруудад хийнэ. Нийтдээ жилд 120 өдөр тоосжилт дарах усалгааг хийхээр тооцлоо. Уурхайд зам 1 га талбай байхаар ТЭЗҮ-д тооцсон байна. *БОНХАЖ-ын сайдын 2015 оны А/301 дүгээр тушаалын 13 дугаар хавсралт* – “Зүлэгжүүлэлт, зам талбайн усалгааны норм”/2л/

усны хэрэглээг тооцвол $10000 \text{ м}^2 * 2 \text{ л}^*/\text{м}^2 = 20 \text{ м}^3/\text{хон} * 120 \text{ өдөр} = 2400 \text{ м}^3/\text{жил}$ нийт зардалд 1 804 320 төг зарцуулахаар төлөвлөлөө.

Хүснэгт 37. Уурхайн 2026 оны зам усалгааны зардал

№	Зориулалт	Нэгж зардал	2025 оны зардал	
1	Усны төлбөр төлөх үнэ	2506 төг Увс нуур, Тэс голын сав газар	$2400 \text{ м}^3 \text{ жил} * 0.3 * 2506 = 1\,804\,320$	Засгийн газрын 2011 оны 302 дүгээр тогтоолын хавсралтаар тооцов.
2	Жолооч цалин, бензин		Үйл ажиллагааны зардалд орсон.	
	Нийт		1 804 320 төг	

БҮЛЭГ 6. НӨХӨН СЭРГЭЭЛТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ

Хар тарвагатай ХК-ийн 2026 онд биологийн нөхөн сэргээлт, техникийн нөхөн сэргээлт төлөвлөгдөөгүй болно.

БҮЛЭГ 7. БИОЛОГИЙН ОЛОН ЯНЗ БАЙДЛЫГ ДҮЙЦҮҮЛЭН ХАМГААЛАХ АРГА ХЭМЖЭЭНИЙ ТӨЛӨВЛӨГӨӨ

7.1. Төслийн дүйцүүлэн хамгаалах ажлын хүрээнд Тэрбум мод хөтөлбөр

Дүйцүүлэн хамгаалах арга хэмжээний хүрээнд Тариалан сумын нутагт 200 ш мод тарихаар төлөвлөсөө.

Хүснэгт 38. Суулгах модны хэмжээ, зардал

№	Мод бутны нэр	Хэмжих нэгж	Тоо хэмжээ	Модны хэмжээ	Нэгжийн үнэ төг	Нийт үнэ төг	Суулгах байршил
1	Улиас	Ш	150	1.2-1.5 м-ийн өндөртэй 15- 25 мм голчтой	5000	750.0	Ойн төгөл
2	Хайлаас	ш	50	1 м уртад 15- 20 ш, 3-5 настай 0.8-1.2 м өндөртэй	4000	200.0	Ойн төгөл
	Нийт		200			950.0	


7.2. Дүйцүүлэн хамгаалах арга хэмжээний хүрээнд булаг шанд, гол горхи, уст цэгийг хашиж хамгаалах

Уур амьсгалын өөрчлөлт болон хүн мал амьтны нөлөөгөөр усны сан бүхий газрын эх үүсвэр болох говийн нүдэн булаг шандын эх дарагдаж, ширгэн усны нөөц багсаж буй сөрөг нөлөөллийг бууруулах зорилгоор булаг шандын эхийг хамгаалж урсцыг нэмэгдүүлэн, хуримтлуулах замаар бэлчээрийн болон газар тариалангийн ус хангамжийг нэмэгдүүлэх шаардлагатай байна.

Гадаргын усыг хамгаалснаар биологийн төрөл зүйлүүд болон хүн малын тоо хязгаарлагдахгүйгээр бүх амьд организм ундаалах боломжтой байдгаараа онцлог үр ашигтай юм.

Хар тарвагатайн нүүрсний уурхайн ойр орчимд 10 орчим будаг шанд байдаг бөгөөд энэхүү булгуудаас ард иргэд болон сумын байгаль хамгаалагч, аймгийн байгаль орчны газраас санал авч эхийг хашаалах ажлыг үе шаттай гүйцэтгэх боломжтой юм. Дор булгийн эхийг хашаалах дараалал арга зүй болон зардлыг тойм байдлаар тооцож оруулав.

Зураг 6. Төслийн талбайтай ойр байрлах булгуудын байршил



Хамгаалах шаардлагатай булгийг тодорхойлох тооцоо судалгааг гаргах. /Захиалагч тал болон сум/

1. Хашиж хамгаалах шаардлагатай булгийн тогтоц төрөл байдлыг ангилах
- 2 Булгийн татмаас онцгой болон энгийн хамгаалалтын бүс дагуу дунджаар 50 м зайд хамгаалагдах талбайг тооцоолох нь зөв бөгөөд хэмжилт судалгааг хийхдээ өвлийн улиралд тэлж хөлдсөн мөстсөн талбайгаар, зуны улиралд булгийн эх орчмын дов сондуул. бут, дэрстэй түнгэ, намаг шалбаагтай талбайн хэмжээг харгалзан үзэж тооцох.
3. Хамгаалахаар сонгосон булгийн хаших талбайн эргэлтийн цэгийг нэг бүрчлэн тогтоож, зураг, хүснэгтээр гарган, газар дээр нь шав тавина.
- 4Хашааны хэлбэр хэмжээг загвар зургаас сонгон хаших булгийн төсвийн төсөөлөл гаргаж гүйцэтгүүлнэ.
- 5 Булаг хамгаалах ажлыг гүйцэтгэлийг техникийн тодорхойлолт загвар зургийн дагуу гүйцэтгэж байгаа эсэхэд тогтмол хяналт тавина.
- 6 Хамгаалсан булгийн гэрчилгээг хөтөлж сумын эд хөрөнгөд бүртгэн цаашдын арчилгаа хамгаалалтыг хариуцан, эзэмшигчид хариуцуулна.

Булаг хамгаалах ажлын арга зүй.

- 1 Хамгаалах булгийг материалыг загвар зураг, техникийн тодорхойлолтын дагуу бэлтгэн чанартай гагнаж бэлдцээ бэлтгэх

2 Булгийн эхийг тойруулан эргэлтийн цэгийн дагуу торон хашаа татахдаа хурц өнцөг гаргахгүй, аль болох дугуйдуу хэлбэртэй хийж мал, амьтан шөргөөхөд биед нь гэмтэл учруулахгүй аюулгүй байдлыг хангахаар тооцоолох.

3 Булгийн эхийг ямар хэлбэр, хэмжээтэйгээр хашаалан хамгаалах нь тухайн булгийн ундарга, ус цуглуулах талбай, нэвчих талбай, ундаалдаг мал зэргээс хамааруулан доорх хэлбэрээр сонгоно.

3.1 Нэвчих талбай багатай, бог мал ховортой мөн аялал жуулчлалын бүс дагуух булгийг хашаалах бол (Зураг 2)-ийн дагуу хэмжээ хийцийг сонгож, шонг суулгахдаа бетонон зуурмагаар бэхжүүлэх нь зөв бөгөөд өнгө үзэмжид анхаарч хашааг төмрийн будгаар будах нь зүйтэй

3.2. Нэвчих талбай томтой эсвэл говийн бүсийн сул хөрстэй, бод мал ундаалдаг, тор шон эвдэх гаднын хүчин зүйлд өртөмтгий булгийг (Зураг-3) ийн дагуу хэмжээ хийцийг сонгон доорх зүйлсийг нэмэлтээр хийх шаардлагатай. Үүнд:

- Дөрвөн метрийн урттай торны 2 м тутамд (Зураг-5)-ийн дагуу бэхэлгээний турбай хийж газарт бэхэлж өгнө.

- Шонгийн хөлд улирлын чанартай хөлдөлт гэсэлт, сулралтаас хамгаалж (Зураг-6) —ийн дагуу бетонон суурь цутгаж бэхлэх.

- Булгийн ус торноос гадагшаа урсан гардаг хэсгийн торыг давхарлаж угольник төмөрт давхарлан гагнах.

3.3. Хүн орж гарах хаалгатай байх бөгөөд (Зураг-4)-ийн дагуу хийгдэж хаалга хаагдахад өөрөө цоожлогддог оньсон түгжээтэй байна.

3.4 Мэдээллийн самбарыг хаалган дээр байрлуулах бөгөөд ус булаг шандын эхийг хайрлан хамгаалах санамж мэдээлэл, хамгаалалтын торонд мал хашихыг хориглодог болон бусад хориглосон зүйл заалтын талаарх мэдээллүүдийг оновчтой оруулсан байна.

3.5. Хамгаалалтын торны бэхэлгээний төмөр шонд бетонон зуурмаг цутгаж, газрын өндөр нам хэвгийгээс хамааран тор, газрын гадарга 2 хоорондох зайг нөхөх үүднээс тухайн бус нутаг элбэг тохиолдох хайрга чулуугаар хаяавч хийсэн байна.

3.6. Хамгаалалтын торны шон, хүрээг төмрийн будгаар будаж өнгө үзэмжид анхаарах.

Булаг хамгаалах ажлын нийтлэг анхаарах асуудал.

1. Хамгаалах булгийн усны байгалийн хөдөлгөөнийн байдлыг алдагдуулахгүй байх нөхцөлийг хангаж ус нь шилжиж өөр газраар гарах, шургаж алга болохоос урьдчилан сэргийлж булгийн ундаргыг хөндөхгүй байх;

2. Ундрэн гарах булгийн ундаргыг ихэсгэхийн тулд түүний гарч байгаа уст үеийн өргөн ба гүнээр нь бүрэн хамгаалалтад авахыг эрмэлзэн булаг гарч байгаа газар болон орчныг цэвэрлэх;

3. Булгийн эх мал амьтны ялгас гаднын нөлөөгөөр дарагдсан бол зориудын аргаар эхийг нь задгайлах арга хэмжээг авч урсгалыг нь чөлөөлөх;

4. Булгийн ойролцоо өрөмдлөг, тэсэлгээний ажил хийхгүй байх;

5. Харзалдаг булгийг хүйтний улиралд ашиглах боломжийг бүрдүүлэх;

6. Нутгийн иргэд рашаан хэмээн нэрлэн хэрэглэж ирсэн рашаан тест булагт сандал, ширээ, сүүдрэвч, машины зогсоол бүхий хүн түр саатан амрах байгууламж барьж болно.

Техникийн үзүүлэлт

Булгийн хамгаалалтын ажлын гол үндсэн хэсэг төмөр тор нь сайн чанарын цайрдсан зэвэрдэггүй гантай төмөр утсаар хийдсэн байх бөгөөд 3 мм— аас дээш диаметртэй, 11х11см нүдтэй, 3-4м урттай, 1.5 м өндөртэй байна.

Торыг хайрцаглахдаа 3 мм зузаантай 40х40мм хэмжээтэй угольник төмрөөр хайрцаглан бат бөх гагнасан байна.

Бэхэлгээний төмөр шон 4-5 мм зузаантай 50d турбай фейх бөгөөд хөлийн урт нь 2м-аас доошгүй өндөртэй байхаар тооцоолж газрын гүнд 0.5м суулгаж 150 маркийн бетон цутгаж хөдөлгөөнгүй болгоно.

Булгийг хашихдаа шон хоорондын зай 3-4м зайтай байх бөгөөд шон тор хоёрыг холбосон 3 бэхлэгээт төмрийг 3 мм зузаантай лист төмрийг 70мм өргөн зүсэж холбоос болгон гагнаж бэхэлнэ.

Дөрвөн метрийн урттай торны дундах бэхэлгээний тулгуур шон булан төмөр буюу угольник төмөр байх бөгөөд 4 мм зузаантай 40х40 хэмжээтэй байна

Орж гарах хаалгыг хамгаалалтын төмөр тороор 0.8 м өргөнтэй хийж, угольник төмрөөр хайрцаглана.

Хүснэгт 39. Техникийн үзүүлэлт

	Материалын нэр,	Тодорхойлолт
1	Сеткин тор	Нүхний хэмжээ 11х11мм, өндөр 1.5 мт урт 3-4м
2	Төмөр шон	өндөр 2 м ф 40мм, ханын зузаан 3 мм
3	Тор хайрцаглах угольник	4 мм зузаантай 40х40
4	Бэхэлгээний тулгуур	4 мм зузаантай 40х40
5	Хаалга	1 м өргөнтэй 1.5 м өндөртэй
6	Мэдээллийн самбар	3мм лист төмөр 50х50

Булгийн эхийг хамгаалах ажлын зардал, төсөв


Нарийвчилсан төсөв гаргахад бидний хувьд хүндрэлтэй байсан учир Монгол улсын худалдан авах ажиллагааны цахим сайт болох Tender.gov.mn сайт дээрээс жишиг үнийн дүнг харахад 1 будгийг 15 сая.төгрөгөөр хашиж хамгаалахаар тендер зарласан байна. иймд энэхүү жишиг үнийн ашиглалаа.


Булаг шандын эхийг хашиж хамгаалах жишиг зураг, техникийн тодорхойлолт

Зураг 7. Хамгаалах булгийн талбай, эргэлтийн цэг тогтоох.




Зураг 8. Хамгаалах булагт орох материалын хэмжээ хийцийн схем зураг.





Зураг 9. Хун орж гарах хаалга, мэдээллийн самбар, бэхэлгээ

Зураг-4




Зураг-5

Дөрвөн метрийн урттай торны дундах бэхэлгээ шон, тулгуурыг булан төмрөөр хийнэ



Зураг-6



Булгийн эх хашаалах зардалд 15 000 000 төгрөг зарцуулахаар төлөвлөсөн.

7.3.Зэрлэг ан амьтанд биотехникийн арга хэмжээ авч өвс, ус бэлдэж өгөх

Хар тарвагатайн уурхайтай ойр байрлах орон нутгийн тусгай хамгаалалттай газар нутгуудад зэрлэг ан амьтанд биотехникийн арга хэмжээ авч өвс ус бэлдэж өгөх ажлын зохион байгуулах шаардлагатай. Доорх 4 орон нутгийн тусгай хамгаалалттай газар нутаг нь лицензийн талбайн баруун, зүүн, хойд хэсгээр байрлаж байна. энэхүү талбайгаас сумын байгаль хамгаалагчтай санал солилцож биотехникийн арга хэмжээг хэрэгжүүлнэ.

Хүснэгт 40. Биотехникийн арга хэмжээ төлөвлөх боломжтой газрууд

№	Сум, дүүргийн нэр	ОНТХГ-ын нэр	Тусгай хамгаалалтад авсан огноо	Тусгай хамгаалалтад байлгах жил	Талбайн хэмжээ	Хамгаалалтад авах үндэслэл
1	Тариалан	Орлогын гол	2017-06-06	10	26583 га	Ой, амьтан, ургамал, усны нөөц газар

2	Тариалан	Ямаат	2017-06-06	10	25351 га	Ой, амьтан, ургамал, усны нөөц газар
3	Тариалан	Бор хавцал	2017-02-10	5	7411 га	Ой, амьтан, ургамал, усны нөөц газар
4	Тариалан	Их баг Адуун нуур	2012-12-28	-	-	Бусад

Эх сурвалж: <https://eic.mn/spalocal/localspa.php?menuitem=1&count=10>

Зураг 10. Био-техникийн арга хэмжээ зохион байгуулж байгаа байдал



Хүснэгт- 1. Био-техникийн арга хэмжээний зардал

№	Нэр төрөл	Тоо хэмжээ	Нэгж бүрийн үнэ	Нийт зардал
1	Боодолтой өвс	100	20 000	2000 000
2	Тээвэрлэлтийн зардал	200км	2000	400 000
3	Ажилчдын зардал	5	100 000	500 000
	Нийт зардал			2900 000

БҮЛЭГ 8. НҮҮЛГЭН ШИЛЖҮҮЛЭХ, НӨХӨН ОЛГОВОР ОЛГОХ АРГА ХЭМЖЭЭНИЙ ТӨЛӨВЛӨГӨӨ

Лицензийн талбайд нүүлгэн шилжүүлэх айл өрх байхгүй уг уурхайн нь 60 жил үйл ажиллагаа явуулж байгаа болно.

БҮЛЭГ 9. ТҮҮХ СОЁЛЫН ӨВИЙГ ХАМГААЛАХ АРГА ХЭМЖЭЭНИЙ ТӨЛӨВЛӨГӨӨ

Монгол улсын “Соёлын Өвийг хамгаалах тухай” хуулийн 17.10-т зааснаар хот суурин, барилга байгууламж барих, шинээр зам тавих, усан цахилгаан станц байгуулах, ашигт малтмалын хайгуул хийх, ашиглах, зэрэг аж ахуйн үйл ажиллагаа явуулахад зориулан газар олгоход түүх, археологийн мэргэжлийн байгууллагаар урьдчилан хайгуул, судалгаа хийлгэж, түүнээс зөвшөөрөл авна гэсэн зүйл заалтын дагуу мэргэжлийн байгууллагаар хийж гүйцэтгүүлсэн байна. Уг олдворуудыг болзошгүй сөрөг нөлөөллөөс урьдчилан сэргийлэхийн тулд дор дурдсан арга хэмжээг авч хэрэгжүүлнэ.

Үүнд:

- Археологийн олдворуудыг түүх, соёлын үл хөдлөх дурсгалт зүйлийг соёл, шинжлэх ухааны асуудал хариуцсан төрийн захиргааны төв байгууллагын зөвшөөрөлгүйгээр хөдөлгөхийг хориглодог бөгөөд үүнтэй холбоотойгоор археологийн олдвор бүхий 7 газарт хашаа хамгаалалт хийж тэмдэгжүүлэн, түүнийг хөндөхгүй байхаар ажиллана.
- Төсөл хэрэгжүүлэх явцад түүх соёлын дурсгалт зүйл нэмж илэрсэн тохиолдолд “Соёлын өвийг хамгаалах тухай” хуулийн 17.12-д зааснаар газрын хэвлийг ашиглах явцад түүх, соёлын дурсгалт зүйл илэрвэл газрын хэвлийг ашиглагч нь ажлаа зогсоож энэ тухай сум, дүүргийн Засаг дарга, цагдаагийн болон уг асуудлыг эрхэлсэн эрдэм шинжилгээний байгууллагад нэн даруй мэдэгдэнэ.
- Барилгын ажлын үед соёлын үнэт зүйлс шинээр тааралдвал, үүнийг Монгол Улсын Соёлын Өвийг Хамгаалах тухай хуулийн дагуу зохих газарт нь даруй мэдэгдэж, холбогдох арга хэмжээг авхуулах зэрэг болно.

Хүснэгт 41. Түүх, соёлын өвийг хамгаалах арга хэмжээний төлөвлөгөө

Нөлөөлөлд өртөх түүх соёлын өвүүд	Хамгаалах арга хэмжээ	Арга хэмжээний цар хүрээ	Нэгжийн өртөг төг	Нийт зардал төг	Хэрэгжүүлэх хугацаа ба давтамж	Баримтлах стандарт ба аргачлал
Төсөл хэрэгжиж буй талбайд шинээр археологи, палеонтологийн олдвор гарсан тохиолдолд	Мэргэжлийн байгууллагуудтай хамтран нүүлгэн шилжүүлэх, музей эсвэл эрх бүхий төрийн байгууллагад шилжүүлэх	Олдвор олдсон тохиолдолд	1000.0	1000.0	Олдвор олдсон тохиолдолд	Соёлын өвийг хамгаалах тухай хуулийн дагуу
Нийт дүн			1000.0 төг			

БҮЛЭГ 10. ОСОЛ, ЭРСДЭЛИЙН МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ

Уурхайн байгаль орчинд үзүүлэх нөлөөллийг бууруулах гол арга зам бол осол, эрсдэлийг гаргахгүй байх юм. Ажилчдыг хөдөлмөр хамгааллын хувцас хэрэгсэл, өглөө бүр ХААБ сургалтыг хийхээр төлөвлөсөн. Мөн авто ослоос сэргийлэн анхааруулах тэмдэг тэмдэглэгээ 10 ш байрлуулахаар төлөвлөсөн. Уурхайн автомашины зогсоол, засварын цэгийг байгуулан ажиллахаар төлөвлөсөн. Эдгээр ажлын зардалд 3 100 000 төгрөг зарцуулах бөгөөд ажилчдын хөдөлмөр хамгааллын хэрэгслээр хангах зардлыг үйл ажиллагааны зардалд тусгахаар төлөвлөсөн.

Хүснэгт 42. Осол, эрсдэлийн менежментийн төлөвлөгөө

№	Болзошгүй аюул, осол, сөрөг нөлөөлөл	Урьдчилан сэргийлэх, хамгаалах арга хэмжээ	Арга хэмжээний цар хэмжээ	Тоо хэмжээ	Нэгжийн зардал, төг	Нийт зардал, төг	Хэрэгжүүлэх хугацаа ба давтамж	Баримтлах эрх зүйн баримт бичиг
1	Ажилчид гэмтэж бэртэх	Ажилчдыг хөдөлмөр хамгаалалтын хэрэгслээр хангаж ажиллах	Бүх ажилчид		Үйл ажиллагааны зардалд орно.		Үйл ажиллагааны туршид	
2	Гал түймэр гарах	Төслийн талбайд галын хор байршуулах	Кемп, үйлдвэр, засварын цэгт	10 ш	250.000	2500.0	Улиралд 1 удаа цэнэглэх	
3	Ажилчдын хайхрамжгүй үйлдлээс болж осол гарах	Ажилчдад хөдөлмөр хамгаалал аюулгүй ажиллагааны сургалт явуулах	Бүх ажилчид	Өдөр бүр	ХААБ мэргэжилтэн		Өдөр бүр	
4	Авто ослоос сэргийлэх	Анхааруулах тэмдэглэгээг байршуулах	Төслийн талбайд	10	60.000	600.000	2026 оны 8 сард	
5	Уурхайн ашиглалтын тээврийн хэрэгслийн засварын үед тос	Уурхайн ашиглалтын тээврийн хэрэгслийн засварын талбайг зураг		Энэхүү зардлыг үйл ажиллагааны зардалд орно.			2026 оны 5 сард	

Увс аймгийн Тариалан сумын нутагт хэрэгжих Хар тарвагатайн нүүрсний уурхайн
2026 оны байгаль орчны менежментийн төлөвлөгөө

MV-001366

	тосолгооны материал асгарч хөрсөнд нэвчих	төслийн дагуу барьж байгуулах					
	Нийт					3100.0	

БҮЛЭГ 11. ХОГ ХАЯГДЛЫН МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ

Энэхүү төсөл нь тогтвортой хэрэгжих төсөл учраас хог хаягдлыг ангилан ялгах, аюултай хог хаягдлыг тусад нь хадгалах зэрэг үйл ажиллагаанууд хэрэгжүүлэх шаардлагатай. Мөн аймгийн БОГазраас хог хаягдлыг ангилан ялгах, ангилан ялгасан энгийн болон аюултай хог хаягдлыг дахивар авах цэгт хүргүүлэх ажлыг хийхийг зөвлөсөн.

Хүснэгт 43. Хог хаягдлын менежментийн төлөвлөгөө

№	Хог хаягдлын ангилал	Сөрөг нөлөөллийг арилгах бууруулах арга хэмжээ	Сөрөг нөлөөллийн хамрах хүрээ	Хэмжих нэгж	Нэгжийн үнэлгээ, мян.төг	Тоо хэмжээ	Нийт зардал, мян.төг	Хэрэгжүүлэх хугацаа давтамж	Баримтлах хууль, журам, стандарт
	1	2	3	4	5	6	7	8	9
1	Ахуйн хог хаягдлыг ангилан ялгах	Хог хаягдлын гэрээг Тариалан сумын ЗД-тай байгуулах төлбөр төлөх	Төслийн хэмжээнд	-		-	900.0	2026 оны 2-р улиралд	Хог хаягдлын тухай хууль
2	Хатуу болон шингэн хог хаягдал	Ахуйн гаралтай хог хаягдлын ангилан ялгаж байх	Төслийн хүрээнд	-	-	-	-	Өдөр бүр	
3		Ангилан ялгасан хог хаягдлыг улиралд нэг удаа зөвшөөрсөн цэгт хүргүүлж байх	Төслийн хүрээнд	-	337.500	4	1350.0	Улиралд нэг удаа	
2	Аюултай хог хаягдал	Ашиглагдсан тос, тосолгооны материал, аккумуляторыг тусгай цэг гарган төслийн талбайд 190 хонгоос ихгүй хадгалан аюултай хог хаягдлыг устгуулах гэрээний дагуу дахин ашиглах цэгт хүргүүлж устгуулах	Засварын газарт	-	1800.0	1	1800.0	Жилд 1 удаа	Байгаль орчин, аялал жуулчлалын сайдын 2018 оны А/18 дугаар тушаалын 1 дүгээр хавсралт “Хог хаягдлын тухай хууль”
		Нийт					4050.0		

БҮЛЭГ 12. ОРЧНЫ ХЯНАЛТ ШИНЖИЛГЭЭНИЙ ХӨТӨЛБӨР


Орчны хяналт-шинжилгээний хөтөлбөрийг бүрэн хэрэгжүүлэх, батлагдсан арга, аргачлалаар дээжлэлт, хэмжилт хийх, холбогдох нарийвчлал, тохиргоог хангасан багаж тоног төхөөрөмжөөр шинжилгээг хийлгэх, үр дүнг шаардагдах нэгжийн системээр гаргах зэрэг бүхий л үйл ажиллагааг Хар тарвагатай ХК хариуцах болно. Байгаль орчны хяналт шинжилгээг тус компанийн байгаль орчны мэргэжилтэн хариуцан гүйцэтгэх эсвэл мэргэжлийн байгууллагатай хамтран Увс аймгийн УЦУОШГ-ын байгаль орчны хяналт шинжилгээ хийлгэх захиалга өгч ажиллана. "Хар тарвагатай" ХК нүүрсний уурхай нь үйл ажиллагааныхаа явцад байгаль орчинд учруулж буй нөлөөлөл, түүний хэмжээ, цар хүрээ, байгаль орчны бүрэлдэхүүн хэсгүүдэд гарч буй өөрчлөлтийг хянаж, байгаль орчныг хамгаалах ажлын үр дүнд тулгуурлан цаашид авах арга хэмжээг нарийвчлан төлөвлөх зорилгоор орчны хяналт, шинжилгээний хөтөлбөрт тусгасан арга хэмжээг бүрэн хэрэгжүүлэх шаардлагатай. Орчны хяналт-шинжилгээний хөтөлбөрийн үр дүнд байгаль орчны төлөв байдалд өөрчлөлт орох, бохирдлын хэмжээ байгаль орчны стандарт, нормоос хэтэрч илрэх тохиолдолд мэргэжлийн байгууллагад яаралтай хандаж, холбогдох арга хэмжээг авч хэрэгжүүлнэ.

Хүснэгт 44. 2026 онд хэрэгжүүлэх орчны хяналт шинжилгээний хөтөлбөр

Бүрэлдэх үүн	Хяналт шинжилгээ хийх үзүүлэлтүүд	Байршил	Хугацаа ба давтамж	Нэгжийн өртөг, төг	Нийт зардал төг/жил	Баримтлах стандарт ба арга аргачлал
Агаарын чанар	нийт тоосжилт, , Нүүрстөрөгчийн исэл, Хүхэрт устөрөгч, Азотын давхар исэл,	Кемп орчим үйлдвэрийн талбайн ойр орчимд Тээвэрлэлтийн замын дагуу	Жилд 1 удаа, 4 цэгээс. Шаардлагат ай тохиолдолд тухай бүрд нь.	63500 төгрөг	381.000	– MNS3113:1981. Агаар мандлын бохирдлыг хэмжих аргачлалын ерөнхий шаардлага – MNS0017-2-3-16:1988. Агаар мандал-Хот, суурингийн агаарын бохирдлын шинжилгээ – MNS3384:1982. Агаар мандал-Агаарын дээжилт шинжилгээ – MNS3113:1981. Хорт утааны ялгаралтыг хэмжих арга – MNS5061:2001. Нүүрс хүчлийн хий-CO₂ тодорхойлох эзлэхүүний арга – MNS0012-014:1991. Ажлын байрны агаар-Бичил орчинг шинжлэх арга

Хөрсөн бүрхэвч	Хөрсний үе давхаргын зузаан (см), элэгдэл эвдрэлийн нөхцөл, ялзмаг %, pH, давсжилт, чийгшилт, Физик шинж чанар, органик бодис, нийт азот, карбонат, Ca, Mg, P ₂ O ₅ , K ₂ O, хөрсний pH, Pb, Cd, As, Zn, Ce –ийн агууламж	Төсөл хэрэгжих талбай Жилд 1 удаа 5 цэгээс зүсэлттэй дээж авна Уурхайн кемп, ил уурхайн шимт хөрсний талбай, баяжуулах үйлдвэр	Жилд 1 удаа, 2 цэгээс	Хөрсний механик бүрэлдэхүүн, ялзмаг 50.0 мян.төг Хөрсний хүнд металл шинжилгээний үнэ 50 .0 мян.төг <i>*Увс аймгийн УЦУОШГ үнэ авав.</i>	500.000	– MNS3985-87 Хөрсний ариун цэврийн байдлын үзүүлэлтийн нэр, төрөл – MNS3310-91 Хөрсний агро химийн үзүүлэлтийг тодорхойлох – MNS2305-94 Дээж авах, савлах, тээвэрлэх, хадгалах журам – MNS(ISO)4814:1999. Атом Шингээлтийн Спектрометрээр шинжилгээ хийх
Усан орчин	Усны ерөнхий химийн шинжилгээ	Бургастайн голоос	Жилд 2 удаа, Бургастайн голоос дээжлэлт хийж лабораторийн шинжилгээн д өгч бактериологийн бүрэн шинжилгээ, хийлгэх.	Ерөнхий хими 46.0 мян.төг Бактериологи 28.0 мян.төг	148.000	– MNS0900:2005 Ундны ус-Ундны усны хяналт шинжилгээ – MNS3935:1986 Ундны ус-Усны шинжилгээнд тавигдах шаардлага – MNS3936:1986 Ундны ус болон үйлдвэрийн ус-Тухайн талбарт нь шинжилгээ хийх – MNS4432:1997 Ундны ус-Хуурай үлдэгдлийн хэмжээг тодорхойлох – MNS3934:1986 Ундны болон үйлдвэрийн ус-Химийн шинжилгээ хийх-дээж авах, хадгалах, зөөвөрлөх – MNS5667-10:2001 Усны чанар-Дээж авах-2-р бүлэг. Хаягдал уснаас дээж авах – MNS5667-2:2001 Усны чанар-Дээж авах-2-р бүлэг Дээж авах арга – MNS4867:1999 Усны чанар-Дээж авах-3-р бүлэг Авсан дээжийг зөөвөрлөх, хадгалах арга
	Томилолт, бензиний зардал	Улаангомоос уурхай хүртэл	2 удаа		2 699 880	–
	Нийт				3 728 880	

Зураг 11. Дээжийн цэгийн байршил



БҮЛЭГ 14. ТУХАЙН ЖИЛИЙН БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨГ ХЭРЭГЖҮҮЛЭХ УДИРДЛАГА ЗОХИОН БАЙГУУЛАЛТЫН ТӨЛӨВЛӨГӨӨ

Удирдлага зохион байгуулалтын төлөвлөгөөнд Байгаль орчныг хамгаалах, үйлдвэрлэлийн осол, гал түймэр, усны аюул мэтийн гэнэтийн ослоос урьдчилан сэргийлэх, осол гарсан тохиолдолд шуурхай хэрэгжүүлэх арга хэмжээг зохион байгуулах талаар 1 жилд 1 удаа сургалт, сурталчилгааны ажлыг мэргэжлийн байгууллага хүмүүстэй хамтран зохион байгуулахаар төлөвлөсөн. 8-р саруудад хийсэн орчны хяналт шинжилгээний хөтөлбөрийн хүрээнд хийгдсэн хэмжилт дээжлэлтийн үр дүнг Тариалан сумын иргэд танилцуулах санал зөвлөгөөг сонгох зорилгоор 9-р сард уулзалт зохион байгуулахаар мөн Байгаль орчны төлөвлөгөөт аудит хийлгэх төлөвлөсөн. Энэхүү ажлын нийт зардал 11000 000 төгрөг байна.

Хүснэгт 45. Тухайн жилийн байгаль орчны менежментийн төлөвлөгөөг хэрэгжүүлэх удирдлага зохион байгуулалтын төлөвлөгөө

№	Хэрэгжүүлэх арга хэмжээ	Хугацаа	Зардал, төг	Хариуцагч
1.	Байгаль орчны удирдлага зохион байгуулалтын арга хэлбэрийг үйл ажиллагаандаа хэрэгжүүлэх чиглэлээр үүрэг хариуцлагын дотоод журам тогтоож мөрдөнө	Төслийн хугацаанд	Дотоод төлөвлөлтөөр	Уурхайн дарга
2.	Байгаль орчныг хамгаалах, үйлдвэрлэлийн осол, гал түймэр, усны аюул мэтийн гэнэтийн ослоос урьдчилан сэргийлэх, осол гарсан тохиолдолд шуурхай хэрэгжүүлэх арга хэмжээг зохион байгуулах талаар 1 жилд 1 удаа сургалт, сурталчилгааны ажлыг мэргэжлийн байгууллага хүмүүстэй хамтран зохион байгуулна.	10 сард	500.000	Уурхайн дарга
3	Хөдөлмөр хамгаалал, аюулгүй ажиллагааны хувцас хэрэгсэл болон болзошгүй галын ажилгүй ажиллагааны багаж хэрэгслээр хангана.	Төсөл хэрэгжих хугацаанд	Үйл ажиллагааны зардалд орсон	Компанийн захирал
4.	Сумаас зохион байгуулж буй урлаг, спортын арга хэмжээг дэмжиж ажиллах	Төслийн хугацаанд	500.000	Компанийн захирал
5.	Ажилчдыг эмнэлгийн анхан шатны үзлэгт хамруулах	1 жилд 1 удаа	Дотоод төлөвлөлтөөр	Компанийн захирал
6	Тариалан сумтай хог хаягдлын гэрээ байгуулах	-	-	Компанийн захирал
7	Сумын айл өрхүүдэд хөнгөлөлттэй нүүрс өгөх	1 жилд 1 удаа	Үйл ажиллагааны зардалд орсон	Уурхайн дарга
8	Байгаль орчны төлөвлөгөөт аудит хийлгэх		10000.0	
Дүн			11000 000	

**БҮЛЭГ 15. ТУХАЙН ЖИЛИЙН БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ ХЭРЭГЖИЛТИЙГ НӨЛӨӨЛӨЛД
ӨРТӨГЧ ОРШИН СУУГЧИД, ОРОЛЦОГЧ ТАЛУУДАД ТАЙЛАГНАХ ХУВААРЬ**

Нийт хийгдсэн ажлуудыг нэгтгэн дүгнэж өмнө 9-р сарын уулзалтаар өгсөн саналыг хэрэгжүүлж эхэлсэн талаар Тариалан сумын иргэд, Увс аймгийн Байгаль орчны газар, Мэргэжлийн хяналтын газруудад танилцуулга хийхээр төлөвлөсөн. Мөн тухайн жилийн биелэлтийн тайланг 2026 оны 11-р сарын 1-ны өдөр аймгийн байгаль орчны газар болон Тариалан сумын ЗДТГ-т хүргэн өгөхөөр төлөвлөсөн.

Хүснэгт 46. Байгаль орчны менежментийн төлөвлөгөөний хэрэгжилтийг тайлагнах хуваарь, зардлын задаргаа

Хугацаа	Нөлөөлөлд өртөгч оршин суугчдад танилцуулах ажил	Зардал	Зохион байгуулах хүний албан тушаал
2026.09.25	Уурхайн үйл ажиллагаатай сум орон нутгийн иргэд, ЗДТГ-ын мэргэжилтэн, танилцуулах	15-25 хүний суудалтай бага оврын автобус хөлсөлнө. Автобусны 1 өдрийн хөлс 500 000 төг. 1 хүний өдрийн хоол 10000 төг. $20 \times 10000 = 200\,000$ төг	Уурхайн дарга болон компанийн захирал
2026.10.05	Уурхайн үйл ажиллагаа, байгаль орчны менежментийн төлөвлөгөөний дагуу хийгдэж буй ажил, нөхөн сэргээлтийн явц зэргийн орон нутгийн иргэдийн төлөөлөлд танилцуулж, бусад сонирхсон асуудлаар чөлөөт ярилцлага хийнэ.	ЗДТГ-ийн хурлын танхимд төлөвлөгөөг танилцуулна.	Уурхайн дарга болон компанийн захирал
2026.11.01	Байгаль хамгаалах талаар хийсэн ажлын жил бүрийн тайланг БОУАӨЯ, аймгийн байгаль орчны газар болон Тариалан сумын ЗДТГ-т хүргэн өгч байна.	Уурхайн дотоод төлөвлөлтөөр	Компанийн захирал, уурхайн дарга
	Нийт зардал	700 000 төг	

БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН 2025 ОНЫ ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ НЭГДСЭН ТӨСӨВ, ДҮГНЭЛТ

Хар тарвагатайн чулуун нүүрсний орд нь Увс аймгийн төв Улаангом хотоос 100 км-ийн зайд Тариалан сумын нутагт орших ба тус аймгийн төв Улаангом нь Улаанбаатар хотоос баруун хойш 1336 км-т оршино. Уг талбай нь нийт 822.42 га талбайг хамаарна.

Уурхайд нийтдээ 47 хүн ажиллах тооцоо гарч байгаа ба ажилчдын дундаж цалин 940.0 мян.төг байна. Төслийн хүчин чадал 200.0 мян.тн нүүрс олборлоход жилд 4.16-24.72 мян.м³ хөрс хуулах ба “Хартарвагатай” ХК-д байгаа уулын үндсэн тоног төхөөрөмж үйл ажиллагааг явуулахад хүрэлцээтэй ба Нэмэлтээр бутлан ангилах хэсэг болон цахилгаан хангамжинд 329.74 сая төгрөгийн хөрөнгө оруулж, төслийн нийт /10 жил/ хугацаанд 5.87 тэрбум төгрөгийн цэвэр ашигтай ажиллана

Уурхайн эцсийн байдлын хүрээн дэх нийт хуулах хөрсний хэмжээ сийрэгжилт тооцсноор 6727.59 мян.м³ болно. Ашиглалтын эцэст овоолгын урт 397 м, өргөн 195.46 м, нийтдээ эзлэх талбайн хэмжээ 7.76 га болно. Гадаад овоолгын давхаруудын хөрсний багтаамж 1370.55 мян.м³ байна. Хөрсний гадаад овоолгыг газрын гадаргуугийн рельефээс хамааруулан 3 давхартай хийхээр ТЭЗҮ-д тусгав. Давхарууд нь тус бүр 15 м, нийт өндөр нь дунджаар 45 м байна. Давхаруудын хажуугийн налуу 35°, овоолгын хажуугийн өнцөг 25°, давхар хоорондын зай ажлын бус хэсэгт 10 м тус тус байна.

“Хар тарвагатай” ХХК нь Байгаль орчин, аялал жуулчлалын сайдын 2019 оны 10 дүгээр сарын 29-ны өдрийн А/618 тоот тушаалаар шинэчлэн баталсан “Байгаль орчны менежментийн төлөвлөгөө боловсруулах, хянан батлах, тайлагнах журам”-ын дагуу Хар тарвагатайн чулуун нүүрсний ордын 2025 оны байгаль орчны менежментийн төлөвлөгөөг боловсрууллаа.

Тухайн жилийн байгаль орчны менежментийн төлөвлөгөө гэж Байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээний тухай хуулийн 9.8-д заасан төлөвлөгөөг ойлгоно. Ерөнхий үнэлгээ хийсэн байгууллагын хянаж баталсан тухайн жилийн байгаль орчны менежментийн төлөвлөгөө нь төслийн үйл ажиллагааг эхлүүлэх, үргэлжлүүлэхийг зөвшөөрсөн байгаль орчны үндсэн баримт бичиг болно.

Хар тарвагатай ХК-ийн Хар тарвагатайн чулуун нүүрсний ордыг ашиглах төслийн 2025 оны байгаль орчны менежментийн төлөвлөгөөний байгаль хамгаалах төлөвлөгөөнд байгалийн нөөц баялгийг ашиглах явцад байгаль орчныг доройтохоос урьдчилан сэргийлэх, сөрөг нөлөөллийг бууруулах, арилгах, үлдэгдэл нөлөөллийг дүйцүүлэн хамгаалах, нөхөн сэргээх, нүүлгэн шилжүүлэх, нөхөн олговор олгох, түүх соёлын өвийг хамгаалахтай холбогдсон арга хэмжээг тодорхойлон, шаардагдах хөрөнгө зардлыг тооцож, хариуцах этгээд, хэрэгжүүлэх хугацаа, баримтлах хууль, журам, аргачлал, стандартыг тодорхойлж тусгалаа.

Хар тарвагатай ХК -ийн Хар тарвагатайн чулуун нүүрсний ордын 2026 оны байгаль орчны менежментийн төлөвлөгөөний орчны хяналт шинжилгээний хөтөлбөрт байгаль орчны төлөв байдлын өөрчлөлт, сөрөг нөлөөллөөс урьдчилан сэргийлэх, арилгах, бууруулах арга хэмжээ үр дүнтэй байгаа эсэх, сөрөг нөлөөллийн эрчим, цар хэмжээ нь зөвшөөрөгдөх хэмжээнд байгаа эсэхийг тогтоох ажиглалт, хэмжилт, дээжлэлт хийх байршил, давтамж, хариуцах этгээд, шинжилгээний арга, шаардагдах зардлыг тооцож орууллаа.

Хар тарвагатай ХК ийн нь 2026 оны байгаль орчны менежментийн төлөвлөгөөг байгаль хамгаалах хууль тогтоомж, байгаль орчны нөлөөллийн нарийвчилсан үнэлгээний үр дүн, батлагдсан байгаль орчны менежментийн төлөвлөгөө (5 жил)-нд үндэслэн боловсруулав.

Сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээний төлөвлөгөөнд техник хэрэгслээс агаарт тархах хорт утааг бууруулах, тоосжилтийг бууруулах зорилгоор замын усалгааг хийх, мониторингийн цэгүүдэд хяналт хийж дээжлэлт хэмжилт хийх ажлуудыг тусгаж өгсөн. Энэхүү төсөл нь 97 жилийн хугацаанд хэрэгжих бөгөөд уурхай бүрэн хүчин чадлаараа ажиллах тохиолдолд 47 хүн ажиллах бөгөөд иймд ажилчдын эрүүл ахуйн шаардлагад нийцсэн мөн байгаль орчиндоо ээлтэй ариун цэврийн эрэгтэй эмэгтэй тусдаа бие засах газрыг барьж байгуулахаар төлөвлөсөн.

Хартарвагатайн нүүрсний ордыг авто-тээвэртэй ашиглалтын системээр ашиглана. Хартарвагатайн нүүрсийг уурхайн ашиглалтанд “Хартарвагатай” ХК-д одоо хэрэглэж байгаа техник, тоног төхөөрөмжүүдийг цаашид үргэлжлүүлэн ашиглана. Уурхайн ашиглалтын 15 дахь жилээс хөрсний дотоод овоолго байгуулна. Уурхайгаас олборлосон нүүрсийг бутлан, ангилна. Иймд үржил шимт хөрсийг салхиний нөлөөгөөр хийсэхээс хамгаалан үр цацаж хамгаалахаар төлөвлөсөн. Энэхүү ажлын нийт зардалд 3 098 320 төгрөг зарцуулахаар төлөвлөлөө.

Уурхайн зам талбайн нөлөөлөлд өртөх зам талбайд тоосжилт дарах усалгааг салхи шуурга ихтэй 4-8 саруудад хийнэ. Нийтдээ жилд 120 өдөр тоосжилт дарах усалгааг хийхээр тооцлоо. Уурхайд зам 1 га талбай байхаар ТЭЗҮ-д тооцсон байна. БОНХАЖ-ын сайдын 2015 оны А/301 дүгээр тушаалын 13 дугаар хавсралт –“Зүлэгжүүлэлт, зам талбайн усалгааны норм”/2л/

усны хэрэглээг тооцвол $10000 \text{ м}^2 * 2 \text{ л}^*/\text{м}^2 = 20 \text{ м}^3/\text{хон} * 120 \text{ өдөр} = 2400 \text{ м}^3/\text{жил}$ нийт зардалд 1 804 320 төг зарцуулахаар төлөвлөлөө.

Дүйцүүлэн хамгаалах ажлын хүрээнд Тариалан сумын нутагт 200 ш мод тарихаар төлөвлөлөө. Тарималжуулахад шаардагдах үр суулгацын тариалах норм, нормативыг тооцохдоо MNS 5918:2008 ургамалжуулах стандартыг үндэслэсэн бөгөөд газрыг нөхөн сэргээх ажлын зардлын үнэлгээний дагуу тарималжуулах ажлын эдийн засгийн тооцоог гаргалаа.

Хар тарвагатай ХК-ийн 2026 онд биологийн нөхөн сэргээлт, тенхикийн нөхөн сэргээлт төлөвлөөгүй болно.

Лицензийн талбайд нүүлгэн шилжүүлэх айл өрх байхгүй уг уурхайн нь 60 жил үйл ажиллагаа явуулж байгаа болно.

Уурхайн байгаль орчинд үзүүлэх нөлөөллийг бууруулах гол арга зам бол осол, эрсдлийг гаргахгүй байх юм. Иймээс уурхай нь 2026 онд аюулын үед авч хэрэгжүүлэх төлөвлөгөөг боловсруулж батлуулахаар төлөвлөсөн. Ажилчдыг хөдөлмөр хамгааллын хувцас хэрэгсэл, өглөө бүр ХААБ сургалтыг хийхээр төлөвлөсөн. Мөн авто ослоос сэргийлэн анхааруулах тэмдэг тэмдэглэгээ 10 ш байрлуулахаар төлөвлөсөн. Уурхайн автомашины зогсоол, засварын цэгийг байгуулан ажиллахаар төлөвлөсөн. Эдгээр ажлын зардалд 3100,0 төгрөг зарцуулах бөгөөд ажилчдын хөдөлмөр хамгааллын хэрэгсэлээр хангах зардлыг үйл ажиллагааны зардалд тусгахаар төлөвлөсөн.

Энэхүү төсөл нь тогтвортой хэрэгжих төсөл учраас хог хаягдлыг ангилан ялгах, аюултай хог хаягдлыг тусад нь хадгалах зэрэг үйл ажиллагаанууд хэрэгжүүлэх шаардлагатай. Мөн аймгийн БОАЖГазраас хог хаягдлыг ангилан ялгах, ангилан ялгасан энгийн болон аюултай хог хаягдлыг дахивар авах цэгт хүргүүлэх ажлыг хийхийг зөвлөсөн. Хог хаягдлын менежментийн төлөвлөгөөнд хог хаягдлын тухай хуулийн шинэчилсэн найруулгаар баталсан хог хаягдлыг ангилан ялгах менежментэд хэвшүүлэх ажилчдад хог хаягдлыг яагаад ялгах тухай сургалтыг

хийх, мөн уурхайн кемпэд 2 ширхэг ангилан ялгах зориулалттай хогийн савыг суурьлуулах зэрэг ажлуудыг хэрэгжүүлэхээр төлөвлөлөө.

Орчны хяналт-шинжилгээний хөтөлбөрийг бүрэн хэрэгжүүлэх, батлагдсан арга, аргачлалаар дээжлэлт, хэмжилт хийх, холбогдох нарийвчлал, тохиргоог хангасан багаж тоног төхөөрөмжөөр шинжилгээг хийлгэх, үр дүнг шаардагдах нэгжийн системээр гаргах зэрэг бүхий л үйл ажиллагааг Хартарвагатай ХК хариуцах болно. Байгаль орчны хяналт шинжилгээг тус компанийн байгаль орчны мэргэжилтэн хариуцан гүйцэтгэх эсвэл мэргэжлийн байгууллагатай хамтран Увс аймгийн УЦУОШГ-ын байгаль орчны хяналт шинжилгээ хийлгэх захиалага өгч ажиллана. "Хар тарвагатай" ХК нүүрсний уурхай нь үйл ажиллагааныхаа явцад байгаль орчинд учруулж буй нөлөөлөл, түүний хэмжээ, цар хүрээ, байгаль орчны бүрэлдэхүүн хэсгүүдэд гарч буй өөрчлөлтийг хянаж, байгаль орчныг хамгаалах ажлын үр дүнд тулгуурлан цаашид авах арга хэмжээг нарийвчлан төлөвлөх зорилгоор орчны хяналт, шинжилгээний хөтөлбөрт тусгасан арга хэмжээг бүрэн хэрэгжүүлэх шаардлагатай. Орчны хяналт-шинжилгээний хөтөлбөрийн үр дүнд байгаль орчны төлөв байдалд өөрчлөлт орох, бохирдлын хэмжээ байгаль орчны стандарт, нормоос хэтэрч илрэх тохиолдолд мэргэжлийн байгууллагад яаралтай хандаж, холбогдох арга хэмжээг авч хэрэгжүүлнэ.

Удирдлага зохион байгуулалтын төлөвлөгөөнд Байгаль орчныг хамгаалах, үйлдвэрлэлийн осол, гал түймэр, усны аюул мэтийн гэнэтийн ослоос урьдчилан сэргийлэх, осол гарсан тохиолдолд шуурхай хэрэгжүүлэх арга хэмжээг зохион байгуулах талаар 1 жилд 1 удаа сургалт, сурталчилгааны ажлыг мэргэжлийн байгууллага хүмүүстэй хамтран зохион байгуулахаар төлөвлөсөн. 8-р саруудад хийсэн орчны хяналт шинжилгээний хөтөлбөрийн хүрээнд хийгдсэн хэмжилт дээжлэлтийн үр дүнг Тариалан сумын иргэд танилцуулах санал зөвлөгөөг сонгох зорилгоор 9-р сард уулзалт зохион байгуулахаар төлөвлөсөн. Энэхүү ажлын нийт зардал 11000 000 төгрөг байна. Уурхайн үйл ажиллагааны хугацаанд Байгаль орчны мэргэжилтэнг ажиллуулахаар төлөвлөсөн.

Нийт хийгдсэн ажлуудыг нэгтгэн дүгнэж өмнө 9-р сарын уулзалтаар өгсөн саналыг хэрэгжүүлж эхэлсэн талаар Тариалан сумын иргэд, Увс аймгийн Байгаль орчны газар, Мэргэжлийн хяналтын газруудад танилцуулга хийхээр төлөвлөсөн. Мөн тухайн жилийн биелэлтийн тайланг 2026 оны 11-р сарын 1-ны өдөр аймгийн байгаль орчны газар болон Тариалан сумын ЗДТГ-т хүргэн өгөхөөр төлөвлөсөн.

Хүснэгт 47. Байгаль орчны менежментийн төлөвлөгөөний нэгдсэн хүснэгт

№	Зардлын утга	Нийт зардал, төг
1	Сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээний ажлын зардал	4 298 320
2	Нөхөн сэргээлтийн ажлын зардал	-
3	Дүйцүүлэн хамгаалах арга хэмжээний төлөвлөгөө Тэрбум мод	950 000
	Булгийн эх хамгаалах	15 000 000
	Биотехникийн арга хэмжээ	2900 000
4	Түүх соёлын дурсгалт эд зүйлийг нүүлгэн шилжүүлэх арга хэмжээний төсөв	1 000 000
5	Осол эрсдэлийн менежментийн төлөвлөгөө	3 100 000
6	Хог хаягдлын менежментээр хийгдэх ажлын зардал	4 050 000
7	Орчны хяналт шинжилгээний хөтөлбөрийн зардал	3 728 880
8	Удирдлага зохион байгуулалтын ажлын зардал	11 000 000
9	Байгаль орчны менежментийн төлөвлөгөөний хэрэгжилтийг тайлагнах хуваарь, зардлын задаргаа	700 000
	2026 оны байгаль орчны менежментийн төлөвлөгөөний нийт зардлын дүн	46 727 200
	Байршуулах төлбөр	23 363 600

2026 оны байгаль орчны менежментийн төлөвлөгөөнд нийт **46 727 200** төгрөг зарцуулахаар төлөвлөөд байна. Байгаль орчныг менежментийн төлөвлөгөөнд тусгасан мөнгөний 50% болох **23 363 600** төгрөгийг Байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээний тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 9,15 дахь заалтад зааснаар Байгаль орчин, аялал жуулчлалын сайдын 2019 оны 10 дугаар сарын 29-ны өдрийн А-618 тоот тушаалын дагуу Байгаль орчныг хамгаалах, нөхөн сэргээлтийн баталгааны тусгай Төрийн сангийн 780090100900013406 тоот дансанд байршууллаа. Хавсралтаар баримтыг үзнэ үү

Увс аймгийн Тариалан сумын нутагт хэрэгжих
Хар тарвагатайн нүүрсний уурхайн 2026 оны
байгаль орчны менежментийн төлөвлөгөө

MV-
001366

ХАВСРАЛТ

ХААН БАНК		БАНК ХООРОНДЫН ШИЛЖҮҮЛЭГ / CLEARING SLIP	
Хүлээн авагчийн/Recipient's Information		Гүйцэтгэх өгнөө / Value Date: 2026 06 25	
Дансны № эсвэл IBAN / Account № or IBAN:	Нэр (Байгууллага эсвэл иргэн) / Name of organization or individual:	Банкны нэр / Bank name:	
100900013406	БН НӨХӨН СЭРГЭЭХ БАТАЛГАА	Төрийн Сан	
Валют / Currency:	Дүн Тоогоор / Amount:	Дүн үсгээр / Amount in words:	
MNT	*23,363,600.00*	*Хорин гурван сая гурван зуун харан гурван мянга зургаан зуун тегрэг*	
Шилжүүлгийн утга / Description:		Шилжүүлгийн дараалал / Transaction queue:	
ХАРТАРВАГАТАЙХХВ-001366 9950 9951 11923			
Шилжүүлэгчийн / Sender's Information			
Дансны № эсвэл IBAN / Account № or IBAN:	Нэр (Байгууллага эсвэл иргэн) / Name of organization or individual:		
5800038449	ХАРТАРВАГАТАЙ		
Валют / Currency:	Дүн Тоогоор / Amount:	Дүн үсгээр / Amount in words:	
MNT	*23,363,600.00*	*Хорин гурван сая гурван зуун харан гурван мянга зургаан зуун тегрэг*	
Хүлээн авагчийн / Receiver's Information			
IBAN	Нэр (Байгууллага эсвэл иргэн) / Name of organization or individual:	Банкны нэр / Bank name:	
100900013406	Байгаль орчны менежментийн төлөвлөгөө	Төрийн Сан Банк	
Валютын шилжүүлгийн хууд дараах бөгөөд:	Валютын шилжүүлгийн хууд дараах бөгөөд:	Валютын шилжүүлгийн хууд дараах бөгөөд:	
For foreign currency transfer, account number is acceptable.	For foreign currency transfer, the field to be filled in latin letters	For foreign currency transfer, bank name is required.	
Шилжүүлэгчийн болон шилжүүлгийн мэдээлэл / Sender and transaction's Information:			
Дансны № эсвэл IBAN / Account № or IBAN:	Валют / Currency:	Мөнгөн дүн / Amount:	Гарын үсэг, тамга / Signature, stamp:
5800038449	₮	23,363,600.00 MNT	1. ХХВ-001366 9950 9951 11923 2. ХАРТАРВАГАТАЙ ХХ
Шилжүүлгийн утга / Description:			
Хартарвагатай ХХ MV-001366, 9950, 9951, 11923			
Энэхүү баримтад бичигдсэн бүх мэдээлэл нь үнэн зөв болохыг дор гарын үсэг зурснаар баталгаажуулж байгаа бөгөөд аливаа хуулийн хариуцлагыг хүлээн зөвшөөрч байна. By signing in this form, I confirm the accuracy of the information provided here and agree to accept any legal responsibility.			
Банкны тэмдэглэл/For Bank use only			
Хураамж/Fee amount:	Журнал №/Journal №:	Банкны ажилтан №/Bank staff №:	Огноо / Date:
100	03664-02	03664	2026/06/25
813404			P010:001644093922